



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага




Европын Холбоо
санхүүжүүлэв



АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн
эрх, үүрэг, оролцоо

Модуль 3. Гэр бүл, нийгэм дэх тэгш байдал



Бусакорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхорст



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага




Европын Холбоо
санхүүжүүлэв



АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн
эрх, үүрэг, оролцоо

Модуль 3. Гэр бүл, нийгэм дэх тэгш байдал



Бусакорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхорст



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



Европын Холбоо
санхүүжүүлэв

АМЬДРАХ УХААНЫ СУРГАЛТ

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн
эрх үүрэг, оролцоо

Модуль 3. Гэр бүл, нийгэм дэх тэгш байдал

Бусакорн Суриясарн, Нелиэн Хаспелз, Розалинда Терхорст

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2020
Анхны хэвлэл 2020

Олон улсын хөдөлмөрийн товчооны хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцын 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр тэдгээрээс иш татан ашиглаж болно. Дахин хэвлэх буюу орчуулах эрхийг авахын тулд ОУХТ-ны Хэвлэл нийтлэлийн албанд (Эрх, зөвшөөрөл) ILO Publications, International Labour Office, CH-1211 Geneva 22, Switzerland гэсэн хаягаар, эсвэл rights@ilo.org гэсэн цахим шуудангаар хандана уу. Олон улсын хөдөлмөрийн товчоо ийм хүсэлтийг таатай хүлээн авах болно.

Хуулбарлах эрхийн байгууллагуудад бүртгэлтэй номын сан, байгууллага болон бусад хэрэглэгчид тэдэнд олгогдсон зөвшөөрлийн дагуу номыг олшруулж болно. Танай улсад буй хуулбарлах эрхийн байгууллагын талаар www.ifrro.org хаягаар мэдээлэл авна уу.

Амьдрах ухааны сургалтын багц: Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо, Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо, БНХАУ, Монгол Улсыг хариуцсан товчоо — Бээжин: ОУХБ, 2020

ISBN:978-92-2-0325605 (хэвлэмэл) ISBN:978-92-2-0325612 (web pdf)

Мөн Англи хэлээр: 3-R Trainers' Kit: Rights, Responsibilities and Representation for Children, Youth and Families. ISBN:978-92-2-0325599 (web pdf), Ulaanbaatar, 2020

МЭДЭГДЭЛ: 2020 ОНЫ ШИНЭЧИЛСЭН ХЭВЛЭЛ (МОНГОЛ, АНГЛИ ХУВИЛБАР)

Энэхүү сургалтын багцыг Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат(MNG/17/50/EUR)"-ны хүрээнд зөвлөх Бусакорн Суриясарн, Х.Өлзийтунгалаг нар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран боловсруулав.

Энэхүү сургалтын багцын үндсэн мэдээллийг дараах эх үүсвэрээс авч, Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн боловсруулав: Empowerment for Children, Youth and Families: 3-R Trainers' Kit on Rights, Responsibilities and Representation, ISBN: 92-2-117849-8 (print), 92-2-117850-1 (web pdf), 92-2-117851-X (CD-ROM), Bangkok (2006) болон the 2017 edition, ISBN 978-92-2-130249-0 (print); 978-92-2-130250-6 (web pdf).

Уг сургалтын багцыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр гаргав. Сургалтын багцад тусгагдсан үзэл бодол нь Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

НҮБ-ын практикт нийцүүлэн гаргадаг ОУХБ-ын хэвлэл нийтлэлд ашиглагдсан тодорхойлолт, тусгагдсан материалууд нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс аливаа улс орон, бүс, газар нутаг, эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаар тогтоохтой холбоотой ямарваа үзэл бодол илэрхийлээгүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа, бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчооноос хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг хүлээн зөвшөөрсөн хэрэг биш юм.

Байгууллагуудын болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүний нэр, үйл явцын талаар дурдсан нь Олон улсын хөдөлмөрийн товчооны зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой байгууллагын нэр, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь ч тэдгээрийг үгүйсгэсэн асуудал биш болно.

ОУХБ-ын хэвлэл, цахим бүтээгдэхүүний талаарх мэдээллийг www.ilo.org/publns хаягаар авах боломжтой.

Уг сургалтын багцын агуулга, түүнд илэрхийлэгдсэн үзэл бодлыг зохиогчид өөрсдөө хариуцах бөгөөд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Хавтасны болон дотор зургийг Ай Си Си Ди ХХК зурав.

Хэвлэлийн эх, график дизайныг Соёмбо принтинг ХХК-д бэлтгэж, Монгол Улсад хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

Сүүлийн 10 жилд Монгол Улсын Засгийн газраас Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-ын 1999 оны 182 дугаар конвенц болон Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенцыг хэрэгжүүлэх чиглэлд олон тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн билээ. Энэхүү хүчин чармайлт нь “Тогтвортой хөгжлийг хангах хөтөлбөр 2030”-ын хүрээнд дэвшүүлсэн 2030 он гэхэд албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүн худалдаалах гэмт хэргийг, 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах зорилтуудтай бүрэн нийцэж байгаа юм.

Тогтвортой хөгжлийн эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өнөөгийн нөхцөл дэх хүүхдийн болон албадан хөдөлмөрийн талаарх ойлголтыг дээшлүүлэх шаардлага зайлшгүй байгааг холбогдох талууд онцолж байна. Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд, залуучууд, гэр бүлтэй ажиллах чиг үүрэг бүхий төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хувьд ийм хэрэгцээ шаардлага бүр чухлаар тавигдаж байгаа юм.

“Амьдрах ухааны сургалт: Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо” сэдэвт сургагч багшид зориулсан сургалтын энэхүү багц нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх зорилготой. ОУХБ-аас анх 2006 онд боловсруулан гаргасан уг сургалтын багц гарын авлага олон оронд амжилттай хэрэглэгдэж байгаагийн дотор Монгол Улсад ОУХБ-АЙПЕК хөтөлбөрийн хүрээнд 2007 оноос хэрэглэж эхэлсэн юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) энэхүү сургалтын багц гарын авлагыг төрийн болон төрийн бус байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд хамгийн тохиромжтой, ач холбогдолтой хэмээн үзэж, Монголын нөхцөлд нийцүүлэн боловсруулахаар шийдвэрлэсэн билээ.

ОУХБ-аас Европын Холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй төслийн¹ хүрээнд уг багц гарын авлагыг ийнхүү шинэчлэн боловсруулж, агуулгыг үндэсний сургагч багш нараар хэлэлцүүлэн баталгаажууллаа. Энэхүү сургалтын багцыг олон хүн ашиглаж, хамгийн хэрэгцээтэй зорилтот бүлэгтээ хүрч үр өгөөжөө өгнө гэж найдаж байна. Энэ цаг үед нүүрлээд буй КОВИД-19 цар тахал эмзэг бүлгийн, ялангуяа хүүхдийн аж байдалд хар сүүдрээ тусгаж, шинэ эрсдэл үүсгэж байна. Үүнээс үүдээд ирэх жилүүдэд эдийн засагт гарч болзошгүй таагүй өөрчлөлтийн нөхцөлд дэлхий даяар засгийн газар, төрийн байгууллагууд, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэлүүд болон иргэний нийгмийн байгууллагууд 2025 он гэхэд хүүхдийн хөдөлмөрийн бүх хэлбэрийг, 2030 он гэхэд албадан хөдөлмөр, орчин үеийн боолчлол, хүн худалдаалах гэмт хэргийг устгах зорилтуудыг хэрэгжүүлэх тун амаргүй сорилттой тулгарч байна. Энэхүү үйлсэд уг сургалтын багц бага ч болов хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Энэхүү багц гарын авлагыг шинэчлэн боловсруулж гаргах боломжийг бүрдүүлж, санхүүгийн харамгүй туслалцаа үзүүлсэн Европын Холбоонд ОУХБ, ГБХЗХГ гүн талархлаа илэрхийлье. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэнийг ч орхигдуулахгүй хамтдаа хөгжих зарчмыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болж, хүн амын эмзэг бүлгийг дэмжих чиглэлд бидний хамтын ажиллагаа үргэлжилнэ гэж найдаж байна.

Мижидсүрэнгийн Энх-Амар
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын дарга

Клэйр Куртье-Мюлдэр
ОУХБ-ын БНХАУ, Монгол Улсыг
хариуцсан товчооны захирал

¹ Төслийн бүтэн нэр: “Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат” (MNG/17/50/EUR)



Агуулга

Өмнөх үг	iii
Талархал	vii
Модулийн агуулга	1
Сэдэв 3.1 Хүү, охин байхын ялгаа нь юу вэ?	3
Дасгал. 3.1.1 Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн онцлог	4
Нэмэлт мэдээлэл: Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон тодорхойлолтууд	8
Дасгал. 3.1.2 Бодит баримт уу эсвэл үзэл бодол уу?	13
СХ 3.1.2 А: Бодит баримт уу эсвэл үзэл бодол уу?	17
СХ 3.1.2 Б: Бодит баримт ба үзэл бодлыг тэмдэглэх хуудас	18
Сэдэв 3.2 Жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл ба хандлага	19
Дасгал. 3.2.1 Хэрэв би... байсан бол	20
Дасгал. 3.2.2 Цагийн хүрд	23
Нэмэлт мэдээлэл: Жендэртэй холбоотой Монгол болон Зүүн Азийн улс оронд дэлгэрсэн хэлц үгс	27
Сэдэв 3.3 Гэр бүлээ аз жаргалтай байлгах нь	29
Дасгал. 3.3.1 Гэр бүлийн аз жаргалыг сонгох нь	30
СХ 3.3.1 А: Гэр бүлийн нөхцөл байдлын зурагт карт	34
Дасгал. 3.2.2 Гэр бүлийн зөрчлийг шийдвэрлэх нь	35
СХ 3.2.3 А: Асуудлыг шийдье	39
Унших материал	44



ТАЛАРХАЛ

Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн боловсруулсан энэхүү багц гарын авлага нь ГБХЗХГ, ОУХБ-ын хамтын ажиллагаа, тууштай хүчин чармайлтын үр дүн юм.

Энэхүү ажилд олон улсын зөвлөх Бусакорн Суриясарн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч үнэтэй хувь нэмэр оруулсныг талархан тэмдэглэж байна.

Мөн ГБХЗХГ-аас байгуулсан сургалтын багцыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн дараах гишүүдэд талархлаа илэрхийлье. Үүнд:

- Пүрэвсүрэнгийн Алгирмаа (Модуль 4, 9, 10)
- Гомбын Ариунчимэг (Модуль 11)
- Жанцандоржийн Азжаргал (Модуль 2, 4, 9)
- Батсүхийн Батсайхан (Модуль 1, 3)
- Цанлигийн Баттуяа (Модуль 4)
- Сосорбурамын Болорцэцэг (Модуль 10, 11)
- Шархүүгийн Галбадрах (Модуль 6, 7)
- ЛГБТ Төв (Модуль 6)
- Баянбаатарын Оюундарь (Модуль 5, 8)
- Борбандийн Санжид (Модуль 3)
- Хуажингийн Өлзийтунгалаг (Сургагч багшийн гарын авлага).

Түүнчлэн энэхүү ажлыг санаачлан эхлүүлж, дэмжсэн ГБХЗХГ-ын дарга асан Очирбатын Алтансүх, дэд дарга Болдбаатарын Халиун нарт талархаж байна. Сургалтын багцыг үндэсний нөхцөлд тохируулан боловсруулахад шаардагдах мэдээллээр хангаж, монгол орчуулгыг хянан дэлгэрэнгүй санал, зөвлөмж өгч хувь нэмрээ оруулахын зэрэгцээ уг ажлыг уялдуулан зохицуулах үүрэг гүйцэтгэсэн ГБХЗХГ-ын Гэр бүл, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Жанцандоржийн Азжаргал, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш Хуажингийн Өлзийтунгалаг нарт талархлаа илэрхийлье. Мөн орчуулагчаар ажилласан Ванжилын Бэрцэцэг, Баттулгын Нармандах, монгол хэлээрх хувилбарыг хянан тохиолдуулсан Балчиндоржийн Туяа нарт талархаж байна.

ОУХБ-ын зүгээс уг ажилд Амгалангийн Лхагвадэмбэрэл, Баярсайханы Баярцэцэг, Бээжин дэх товчооны Париссара Льюкийт, Бангкок дахь Зохистой хөдөлмөрийг дэмжих багийн Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Барати Флюг нар хөтөлбөрийн, захиргааны болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан болно.



МОДУЛЬ 3. ГЭР БҮЛ, НИЙГЭМ ДЭХ ТЭГШ БАЙДАЛ

Модулийн агуулга

Энэхүү модуль нь тэгш байдлын тухай нийтлэг асуудлууд, ялангуяа гэр бүл дэх эрэгтэй эмэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн эрх тэгш байдлын асуудлыг онцлон танилцуулах юм. Модульд багтсан дасгал ажлууд нь эрэгтэй хүүхэд, эмэгтэй хүүхэд, эрэгтэй хүн, эмэгтэй хүн байна гэдэг нь юу гэсэн үг болохыг илүү гүнзгий ойлгоход тусална. Хүүхэд, залуучууд болон гэр бүлийн гишүүд өөрийн хүйс, үүрэг хариуцлагын талаарх ойлголт, хандлагаа тодорхойлоод зогсохгүй энэ талаарх бусдын байр суурь, хандлагыг судлах болно. Улмаар өөрийн гэр бүл болон нийгэмд зонхилдог жендэрийн талаарх үнэт зүйл, хэм хэмжээ болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд хандах хандлага, тэдний хоорондын харилцаа зэргийг задлан шинжилнэ. Хүн бүр өөрийгөө бүрэн дүүрэн хөгжүүлэх эрхтэй болохыг, энэ эрхээ эдлэхэд нь гэр бүлийн гишүүдээ хэрхэн дэмжих талаар мэдэх болно. Түүнчлэн гэр бүлд үүсдэг зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар дасгал ажиллана.

Энэхүү модуль 3 сэдвээс бүрдэнэ:

- Сэдэв 3.1 Хүү, охин байхын ялгаа нь юу вэ?
- Сэдэв 3.2 Жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл ба хандлага
- Сэдэв 3.3 Гэр бүлээ аз жаргалтай байлгах нь

Сэдэв 3.1 Хүү, охин байхын ялгаа нь юу вэ?	Зорилго	Хугацаа
Дасгал. 3.1.1 Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн онцлог	- Хүйс ба жендэрийн ялгааг таних - Амьдралын ихэнх хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдийн нөхөн үржихүйн үүргээс бусад ялгаа нь нийгмээс оноосон байдгийг ойлгох - Жендэрийн хэм хэмжээ, уламжлагдан тогтсон хандлагыг гэр бүл болон нийгмийн хүрээнд өөрчилж болохыг ойлгох	45 минут
Дасгал. 3.1.2 Бодит баримт уу эсвэл үзэл бодол уу?	Хүйс болон жендэрийн үүргийн талаарх бодит баримт болон үзэл бодлын ялгааг ойлгох	60 минут

Сэдэв 3.2 Жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл ба хандлага	Зорилго	Хугацаа
Дасгал. 3.2.1 Хэрэв би... байсан бол	- Жендэрийн үүргийн талаарх өөрийн хандлагаа таних - Өөрийн гэр бүл, орчин тойрондоо давамгайлж буй жендэрийн үүргийн талаарх хандлагыг шинжих - Охид, хөвгүүдэд шударга, тэгш боломж олгохын тулд юуг өөрчлөх хэрэгтэй байгааг тодорхойлох	45-60 минут
Дасгал. 3.2.2 Цагийн хүрд	- Өөрийн соёлын жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл, хандлагад дүн шинжилгээ хийх - Цаг хугацааны явцад жендэрийн үүрэг болон үнэт зүйлс өөрчлөгдөж, өмнө нь хүлээн зөвшөөрөгдөж байсан үүрэг, үнэт зүйл өнөөгийн нийгэмд зохицохгүй байж болохыг ойлгох	45-75 минут
Сэдэв 3.3 Гэр бүлээ аз жаргалтай байлгах нь	Зорилго	Хугацаа
Дасгал. 3.3.1 Гэр бүлийн аз жаргалыг сонгох нь	- Гэр бүлийн харилцааны талаарх өөрийн хандлагаа таних - Гэр бүл аз жаргалтай байхад юу чухал болохыг ойлгох - Хүүхдийнхээ өмнө хүлээх эцэг, эхийн үүрэг хариуцлагыг ухамсарлах - Гэр бүлийн хүрээнд хүүхэд, өсвөр насныхны эдлэх эрхийн талаарх өөрийн ойлголтоо үнэлэх	45-60 минут
Дасгал. 3.3.2 Гэр бүлийн зөрчлийг шийдвэрлэх нь	- Гэр бүлийн зөрчил нь заримдаа гишүүдийн үнэт зүйлсийн зөрүүтэй байдлаас үүсдэгийг ойлгох - Гэр бүлийн үүрэг хариуцлагыг эерэг талаас нь харж сурах - Гэр бүлийн гишүүдийн хоорондын зөрчлийг шийдэх аргуудыг хэрэглэж турших	45-60 минут
Нийт хугацаа 4 цаг 45 минут – 6 цаг		

Сэдэв 3.1 Хүү, охин байхын ялгаа нь юу вэ?



Агуулга

Энэхүү сэдэв эрэгтэй эсвэл эмэгтэй байх нь юу гэсэн үг болохыг оролцогчдод тайлбарлаж, өөрийгөө танин мэдэхэд нь туслах болно. Оролцогчид хүйсэд оноосон үүргийн талаарх өөрсдийн төсөөллийг задлан шинжиж, хүйс болон жендэр гэх ойлголтын тухай, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгааг ойлгох болно. Улмаар, хэрэв жендэрийн ялгаанаас шалтгаалж хүмүүс хоорондын харилцаанд шударга бус байдал үүсэж байвал түүнийг өөрчлөх боломж байдаг тухай мэдэж авна.



Үндсэн мэдээлэл

- Хөвгүүд охид, эрэгтэй эмэгтэй хүмүүс биологийн талаасаа тэдний нөхөн үржихүйн үүргийг тодорхойлох бэлэг эрхтэн, даавар ялгаруулах байдал зэрэг хэд хэдэн онцлог ялгаатай төрдөг ба үүнийг нь хүйс/секс хэмээн тодорхойлдог.
- Нөхөн үржихүйн үүргээс гадна амьдралын ихэнх хүрээнд (тухайлбал, зан үйл, хандлага, нийгэм болон гэр бүлд гүйцэтгэх үүрэг зэрэг) хүйсийн ялгаа нь нийгмээс ихээхэн хамаардаг. Энэхүү ялгааг жендэрийн ялгаа хэмээн нэрлэдэг бөгөөд эдгээр ялгаа нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж болно.
- Жендэрийн үүргийн тухай хэвшмэл үзэл нь ямар ч нийгэмд оршин байдаг ба үүнээс шалтгаалан жендэрийн тэгш эрх алдагдаж байдаг. Иймд хүйс болон жендэрийн тухай бодит баримт ба үзэл бодлын хоорондын ялгааг сайтар таньж, ямарваа нэгэн мэдээлэлд итгэхээсээ өмнө хянаж магадлал сурах нь маш чухал.
- Нас, хүйс харгалзалгүйгээр гэр бүлийн гишүүн бүр хүн ёсоор хүндлүүлж, өөрийн нөөц боломжоо бүрэн нээн, өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангагдах эрхтэй.



Дасгалууд

3.1.1 Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн онцлог

3.1.2 Бодит баримт уу эсвэл үзэл бодол уу?



Холбогдох сэдвүүд

1.1 Би хэн бэ?

3.2 Жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл ба хандлага

3.3 Гэр бүлээ аз жаргалтай байлгах нь

6.1 Өөрчлөлт ба бэлгийн харилцаа

Дасгал 3.1.1 Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн онцлог



Зорилго

- "Хүйс" ба "жендэр"-ийн ялгааг таних
- Амьдралын ихэнх хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдийн нөхөн үржихүйн үүргээс бусад ялгаа нь нийгмээс оноосон байдгийг ойлгох
- Жендэрийн хэм хэмжээ, уламжлагдан тогтсон хандлагыг гэр бүл болон нийгмийн хүрээнд өөрчилж болохыг ойлгох



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид (хүүхдүүдийг залуучууд, насанд хүрэгчдээс тусад нь оролцуулна)



Хугацаа

45 Минут



Суудал зохион байгуулалт

3х6 метр талбай гаргаж хагас дугуй хэлбэрээр сандал байрлуулна.



Ашиглах материал

- 2-3 метрийн өргөнтэй самбар эсвэл цулгуй хана эсвэл дэлгэц цаасны 2 самбар
- Самбар байхгүй тохиолдолд 3 хуудас самбарын цаас
- 2-3 өнгийн самбарын үзэг, наадаг цаас эсвэл шохой



Сургалтын хэрэглэгдэхүүн

Нэмэлт мэдээлэл: Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон тодорхойлолтууд



Сургалт зохион байгуулах алхмууд ²

1. Зургийн уралдаан – 15 минут
2. Хөвгүүд, охид/Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог – 15 минут
3. Хүйс үү, жендэр уу? – 15 минут

² WWRGE Manual-Cambodia by Rosalinda Terhorst et al. (ILO: Bangkok, 2004), Module 3.2 Values and Attitudes – Sexy Relay Race.

Бэлтгэл

- Нэмэлт мэдээлэл хэсгээс “хүйс” болон “жендэр”-ийн ялгаа, жендэрийн үүрэг, жендэрийн үнэт зүйл, хандлага, хэм хэмжээ, түүнчлэн жендэрийн тухай хэвшмэл үзэл зэрэг жендэрийн үзэл баримтлалтай танилцана. Мөн жендэрийн тэгш байдлыг дэмжих нь яагаад чухал талаар ойлголттой байвал сайн.
- Дасгал ажиллуулахаас өмнө 3х6 метрийн хэмжээтэй зай гаргах эсвэл хоосон өрөө бэлдэх хэрэгтэй. Хэрэв самбар байхгүй бол өрөөний захад дэлгэц цаасны хоёр самбар байрлуулж, эсвэл цулгүй хана ашиглаж болно. Хоёр самбарын хооронд ойролцоогоор 1м зайтай байна. Нэг самбар дээр “ЭРЭГТЭЙ”, нөгөө дээр нь “ЭМЭГТЭЙ” гэж бичнэ (Хэрэв оролцогчид хүүхдүүд байвал “ХҮҮ”, “ОХИН” гэж бичнэ). Хоосон дэлгэц цаас бүрээс 2 метрийн зайтай шохой эсвэл наадаг цаасаар “Гараа” гэсэн тэмдэг тавина.

Алхам 1. Зургийн уралдаан – 15 минут

Оролцогчдод зургийн уралдаан зохион байгуулна гэдгийг мэдэгдэнэ.

- Оролцогчдыг хоёр баг болгон хуваахдаа эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн тоо тэнцүү байхад анхаарна.
- Баг тус бүрийг эрэгтэй, эмэгтэйгээр нь сөөлжүүлэн жагсаагаад, хамгийн эхний хүнийг “Гараа” гэсэн бичгийн хажууд зогсооно.
- Дүрмийг бүрэн тайлбарлаж, оролцогчид бүрэн ойлгохоос өмнө самбарын үзэг өгөхгүй.
- Уралдааны дүрмийг дараах байдлаар тайлбарлана:
 - Нэг баг нь эрэгтэй хүн/хүүхдийг, нөгөө баг нь эмэгтэй хүн/хүүхдийг толгойноос нь хөл хүртэл бүтнээр нь, аль болох хурдан зурах даалгавартай.
 - Эхлэх дохио өгөнгүүт баг бүрээс нэг гишүүн үзэг салгалгүй нэг зураас зураад, самбарын үзгийг дараагийн хүнд шилжүүлэх ба нөгөө хүн нь мөн нэг зураас зураад дараагийн хүнд дамжуулах замаар уралдаан үргэлжилнэ.
 - Багийн гишүүн бүр дор хаяж нэг зураас зурсан байх ёстой. Аль болох хурдан гүйцэтгэхийг хичээнэ!
 - Баг бүр эрэгтэй, эмэгтэй хүний онцлог шинжүүдийг бүрэн харуулахыг хичээх хэрэгтэй.
 - Эрэгтэй/эмэгтэй хүнийг/хүүхдийг хамгийн тод томруун дүрсэлж чадсан баг түрүүлнэ.

Хамгийн эхний хүнд самбарын үзэг өгөөд “Эхлэх” дохио өгнө. Зурааснууд нэмэгдэн, зураг нь тодорхой хэлбэр дүрстэй болж эхлэнгүүт үлдсэн хугацааг зарлаж, оролцогчдын хурдтай, хөгжөөнтэй өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжинэ.

Зургууд дээр тухайн хүний биологийн болон нийгмийн онцлогууд ялгарч эхлэнгүүт (тодруулбал эмэгтэй хүнийг хөхтэй, жирэмсэн, хүүхэд тэвэрсэн байдлаар, эрэгтэй хүнийг сахалтай, төвөнхтэй, булчинтай, мөн үс засалт, хувцаслалтын ялгаа г.м.) уралдааныг зогсооно.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Хэрэв оролцогчид зөвхөн хувцас зураад, биологийн онцлогийг харуулахгүй байвал “Хэрэв хувцсыг нь тайлбал ямархуу бие харагдах бол?” зэргээр санаа өгч болно. Гэхдээ оролцогчдын соёл, заншил зэрэгт мэдрэмжтэй байж, эв дүйтэй хандаарай. Бэлэг эрхтэн зурахаас ичиж байвал бүү хүчлээрэй. Хөх, сахал зэрэг биологийн зарим онцлогийг зурсан бол хангалттай.

Алхам 2. Эрэгтэй, эмэгтэй хүн/хүүхдийн онцлог ялгаа – 15 минут

Оролцогчдыг суудалдаа суухыг урьж, зургуудын талаар хамтдаа ярилцана.

- Оролцогчдоос дараах асуултыг асууна:
 - Зургууд тодорхой байна уу? Юугаараа адил, юугаараа ялгаатай байна вэ?
 - Эрэгтэй хүн/хүүхдийн ямар онцлог шинжүүдийг дүрсэлсэн байна вэ?
 - Эмэгтэй хүн/хүүхдийн ямар онцлог шинжүүдийг дүрсэлсэн байна вэ?
- Дурдсан онцлог шинжүүдийг зургийн хажууд эсвэл тусдаа самбарын цаасан дээр тэмдэглэнэ.
- Жагсаасан онцлог бүрийг нэг нэгээр нь нэрлэж, тухайн онцлог шинж эсрэг хүйсийн хүнд байх боломжтой эсэхийг оролцогчдоос асууна.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Хүүхдийн зурсан эрэгтэй, эмэгтэй хүн нь залуучууд, насанд хүрэгчдийн зурсан зурагтай харьцуулбал биологийн зарим нэг онцлогийг тодорхой тусгаагүй байж болно. Хэрэв хүүхдүүдийн зурсан зурагт бие бялдарын болон нийгмийн онцлогийг сайн тусгаагүй байвал охид, хөвгүүдийн тухай бодоход тэдэнд төрдөг санаанаас 5-ыг хэлэхийг санал болгоорой.

- Оролцогчдын үзлээр өөрчлөгдөж болох онцлогуудыг тэмдэглэнэ. Онцлог шинж тус бүрийг эсрэг хүйсийн хүнд илэрч болох эсэхийг асууна. Жишээ нь: хөвгүүд даашинз өмсөж, эрчүүд үсээ ургуулж, охид хөл бөмбөг тоглож, эмэгтэй хүн цагдаа болж болох уу г.м. Хангалттай олон шинж тэмдэг хэлэлцсэний дараа дараах асуултыг асууна:
 - Аль онцлог шинжүүд зөвхөн аль нэг хүйсэд хамаарах вэ? (Биологийн ялгаа болох бэлэг эрхтэн, жирэмслэлт, сахал, төвөнх г.м.)
 - Аль онцлог шинжүүдийг өөрчлөх боломжгүй вэ? (Төрөлхөөс заяасан, мөн даавраас шалтгаалсан биологийн онцлогууд)
 - Аль онцлог шинжүүд аль аль хүйсэд илэрч болох вэ? (төрөлхийн биш, амьдралын явцдаа олж авсан нийгмийн онцлог шинжүүд: гадна төрх, хувийн онцлог, гэр бүлийн, мэргэжлийн болон нийгмийн үүрэг)
- Хүйс болон жендэр хэмээх ойлголтуудыг тайлбарлана:
 - “Хүйс” гэдэг нь төрөхөөс заяасан, бэлэг эрхтэнтэй холбоотой ойлголт. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүйсийг тодорхойлсон биологийн онцлог шинж бөгөөд зөвхөн эрэгтэй хүнд л эр эс боловсордог, зөвхөн эмэгтэй хүн л өндгөн эс боловсруулж, жирэмсэлдэг.
 - “Жендэр” гэдэг ойлголт нь эрэгтэй, эмэгтэй хүний талаарх нийгэм-соёлын төсөөлөлтэй холбоотой (эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн үүрэг, онцлог, зан үйл гэх мэт). Жендэр болон хүйс хоёр хоорондоо адилгүй.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Дасгалыг илүү сонирхолтой болгохын тулд өнөөгийн хэм хэмжээ болон жендэрийн үүргээс ялгаатай эртний Монголын болон бусад соёлын хүмүүсийн зургийг харуулж болно. Жишээ нь: Монгол эрчүүд урт үстэй байсан, банзалтай Шотланд эрчүүд, өмд өмссөн орчин үеийн Ази бүсгүйчүүд, эрэгтэй сувилагч, эмэгтэй нисгэгч, барилга дээр хамт ажиллах эрэгтэй болон эмэгтэй хүмүүс, оёдол болон хоол хийж байгаа эрэгтэй г.м. Өөр өөр соёлд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувцаслалтын хэв маяг ялгаатай бөгөөд цаг хугацааны явцад хүйсийн үүрэг өөрчлөгдөж болдгийг эдгээр зургаас харж болно.

Алхам 3. Хүйс үү, жендэр үү – 15 минут

Оролцогчид хүйс болон жендэрийн үүргийн ялгааг ойлгосон эсэхийг шалгаж дасгалыг үргэлжлүүлнэ. Одоо зарим өгөгдлийг унших ба оролцогчдоос уг өгөгдөл хүйс, жендэр хоёрын

алинд нь хамаарч байгааг хэлэхийг хүснэ. Хэрэв өгөгдөл биологийн онцлогийг тусгасан бол (X), нийгмийн онцлогийг тусгасан бол (Ж) гэж тэмдэглэнэ.

Эхлээд нэгээс хоёр өгөгдлийг хэлж туршиж үзээд, оролцогчид ойлгосон бол дараагийн өгөгдлийг нэг нэгээр нь уншина:

1. Эмэгтэй хүн жирэмсэлдэг. (X)
2. Эрэгтэй хүн богино үстэй, эмэгтэй хүн урт үстэй. (Ж)
3. Эмэгтэйчүүд хүүхдээ хөхүүлдэг. (X)
4. Эр хүн бол өрхийн тэргүүн. (Ж)
5. Эмэгтэйчүүд, охидууд гэрийн ажил хариуцаж, бага насны хүүхдээ асардаг. (Ж)
6. Эрчүүд нүүр болон биедээ үстэй, бас төвөнхтэй. (X)
7. Эрчүүд барилгын инженер, механикчаар ажилладаг. (Ж)
8. Эмэгтэйчүүдэд сарын тэмдэг ирдэг. (X)
9. Хөдөөний эмэгтэйчүүд олон хүүхэдтэй байдаг. (Ж)
10. Бүргэд агнах тэмцээнд цөөхөн эмэгтэйчүүд оролцдог. (Ж)
11. Орчин үед хөвгүүд, охид бүгд ухаалаг утас, компьютер гэх болсон. (Ж)

Дараах гол санааг онцлоорой:

- **Хөвгүүд охид, эрэгтэй эмэгтэй хүмүүс биологийн хувьд бие биеэсээ ялгарах зарим онцлогтой төрдөг.** Энэ нь тэдний нөхөн үржихүйн үүргийг тодорхойлох даавар болон бэлэг эрхтэн юм. Тодруулбал, эрчүүд эр эс боловсруулж, эмэгтэйчүүд жирэмсэлж, хүүхэд төрүүлдэг. Үүнийг хүйс гэнэ.
- Амьдралын ихэнх талбарт хоёр хүйсийн хоорондын нөхөн үржихүйн үүргээс бусад ялгааг нийгмээс оноосон байдаг ба эдгээр (зан үйл, хандлага, гэр бүл болон нийгэм дэх үүрэг, хүйсийн илрэл болох хувцаслалт, гоёл чимэг гэх мэт) нь нийгмийн хэм хэмжээ, соёл заншлаас ихээхэн хамааралтай байдаг.
- Эрэгтэй, эмэгтэй хүний өмсөх хувцас, хийх болон хийх ёсгүй зүйл зэрэг нийгмээс оноосон **жендэрийн ялгаа** нь өөр өөр соёлд, нэг соёлын хүрээнд, нэг эринээс нөгөө эринд өөр өөр байдаг. Өөрөөр хэлбэл цагийн эрхээр өөрчлөгдөх боломжтой, өөрчлөгдсөөр ирсэн зүйл юм.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Хот суурин газрын зарим оролцогч гоо сайхны мэс засал болон хүйс солих ажилбарын тухай ярилцахыг хүсэж болох юм. Сургагч багш нар энэ талаар нээлттэй ярилцаж болох ч хэт их хугацаа зарцуулж, зарим оролцогчдыг эвгүй байдалд оруулахаас сэрэмжлээрэй. Ийм асуудал хөндөгдөх үед хэрэглэж болох нэг хариулт нь: байгальд эр, эм гэсэн хоёр л хүйс байдаг гэсэн ойлголт олон зуун жил оршсоор ирсэн ч шинжлэх ухааны сүүлийн үеийн нээлтүүд нь “хүйс” гэдэг ойлголтын агуулга шинэчлэгдэн өөрчлөгдөхөд хүргэж байна³. Биологийн хүйс нь (төрөхөд өгөгдсөн хүйс) эр, эм хоёр хүйс төдийгүй өөр бусад хувилбарыг агуулдаг болохыг сүүлийн үеийн судалгаагаар тогтоосон байна.

Хүйс нь зөвхөн бэлэг эрхтнээр төдийгүй ген, хромосом, бэлгийн даавар болон бэлгийн бусад шинж тэмдгээр тодорхойлогддог. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бие махбодын ялгааг технологийн дэвшлээр багасгаж болох ч биологийн нөхөн үржих чадвар гэх хүний төрөхөд нь хамт бий болдог биологийн ялгааг арилгаж чадахгүй. Мэс засалчид хиймэл хөх суулгаж, төвөнхийг авч, бэлэг эрхтнийг өөрчилж чадна. Эрчүүд эм даавар ууж, эм хүн шиг болох, эмэгтэйчүүд эр даавар ууж, хөхөө авахуулж эр хүн шиг болж болох ч хүйсээ сольсон эр хүнд өндгөвч бий болж, үр тогтоож, хүүхэд тээн төрүүлж, сүү гаргаж чадахгүйтэй адил эмэгтэй болж төрсөн хүн яаж ч хичээгээд эр эс боловсруулж чадахгүй. Аль ч тохиолдолд хүний бэлгийн баримжаа нь хүйсийн болон жендэрийн онцлогийн аль алийг нь өөртөө агуулах бөгөөд хүмүүсийг зөвхөн нөхөн үржихүйн үүргээр тодорхойлох биш, өөрөөр хэлбэл хүн зөвхөн нөхөн үржих үүрэгтэй биш, бид нийгмийн гишүүн бөгөөд бидний үүрэг нь бидний биологийн хүйсээс хальж гарах олон хүчин зүйлээр тодорхойлогддог.

³ Claire Ainsworth, "Sex redefined", *Nature*, 18 February 2015, <http://www.nature.com/news/sex-redefined-1.16943>



Нэмэлт мэдээлэл. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон тодорхойлолтууд⁴

Ихэнх нийгэмд хүүхдүүдийн эхээс төрөхөд оногдсон биологийн хүйс нь тэдний нийгмийн гарал үүсэл, арьсны өнгө, яс үндэс, гэр бүл нь хот эсвэл хөдөө орон нутагт амьдардаг зэрэг бусад чухал хувьсагчийн зэрэгцээ амьдралд учирч болох боломжуудад нөлөөлдөг. Төрсөн цагаас нь эхлэн нийгмийн зүгээс охид, хөвгүүдэд өөр өөр үүрэг оноож, өөр өөр боломж олгодог. Ийнхүү бид багаасаа тухайн нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдөхийн тулд эрэгтэй хүн, эмэгтэй хүн ийм байх ёстой, тийм байх ёсгүй гэсэн үзэл бодолд баригдаж, түүнд нь захирагдаж өсдөг (жишээлбэл охид өхөөрдөм байх, хөвгүүд уйлж болдоггүй).

Хүйс болон жендэрийн ялгаа юу вэ?



- **Хүйс** гэдэг нь эхээс төрөхөд оногдсон биологийн онцлог бөгөөд эрэгтэй эмэгтэй хүмүүс, охид хөвгүүдийн хоорондын ген болон нөхөн үржихүйн тогтолцоогоор тодорхойлогдох биологийн ялгааг илэрхийлдэг. Жишээлбэл, эмэгтэй хүн л өндгөн эс боловсруулж хүүхэд төрүүлдэг, харин эрэгтэй хүн л эр бэлгийн эс бий болгодог.



- **Жендэр** гэдэг нь эрэгтэй болон эмэгтэй хүний үүрэг, онцлог, зан үйлийн талаар нийгэмд уламжлагдан тогтсон ойлголт юм. Жендэрийн ялгаатай байдлын тухай ойлголтыг хүүхэд багаасаа эзэмшдэг бөгөөд соёл дотроо болон өөр өөр соёлын хооронд ялгаатай байж, цаг хугацааны эрхээр өөрчлөгдөж байдаг. Жишээлбэл, олон оронд эмэгтэйчүүд бага насны хүүхдээ асрах үүрэгтэй байсан бол сүүлийн үед эрчүүд ч мөн хүүхдээ асрах хандлага нэмэгдсээр байна.

- Хүмүүс төрөхдөө олсон хүйсээ барагтай өөрчилдөггүй ч өөрийн гэр бүл болон нийгмийн хүрээнд жендэртэй холбоотой хандлага шударга бус байгаа тохиолдолд жендэрийн ялгаа хандлагыг өөрчилж болно.

Жендэрийн үзэл ойлголт нь охид/эмэгтэйчүүд, хөвгүүд/эрэгтэйчүүдийн өөрийгөө илэрхийлэх, биеэ авч явах байдал, яриа, хувцаслалт зэрэгт нөлөөлөхийн зэрэгцээ ажил, амьдралын боломжийг нь ч тодорхойлж байдаг. Зарим гэр бүл, орон нутаг, нийгмийн орчинд хүйсийн хатуу чанга хэм хэмжүүр байдгаас болж зөвхөн охид бүсгүйчүүд гэлтгүй хөвгүүд, эрчүүдийн хувьд ч өсөн дэвжих, хөгжих боломж хязгаарлагдах нь элбэг. Ийм үзэл ойлголтууд нь ихэнхдээ бодит байдалд нийцдэггүй бөгөөд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэр бүл, ажил мэргэжил, нийгэмд гүйцэтгэж буй бодит хувь нэмрийг халхалж дарагдуулж болно.

Иймд бодит баримт ба хувийн үзэл бодлын хоорондын ялгааг ойлгож, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэж буй үүргийг бодитоор ажиглаж, түүнийгээ ийм байх ёстой, тэгэх ёстой, ингэж чадахгүй г.м. хүмүүсийн хэвшмэл үзэлтэй харьцуулж байх хэрэгтэй.


- **Жендэрийн үүрэг** гэдэг нь охид, хөвгүүд, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэдэг үйл ажиллагаатай холбоотой. Жишээлбэл, хөвгүүд аавдаа гэрийн гаднах ажилд тусалдаг бол охид ээжийнхээ гэр доторх ажилд тусалдаг г.м. Жендэрийн үүрэг нь тухайн нийгэмд

⁴ Gender Mainstreaming Strategies in Decent Work Promotion: Programming Tools – GEMS Toolkit by ILO (ILO: Bangkok, 2010); UNFPA, Trainers' Guide for CSE for TVET (Lao PDR, 2019), 5. Understanding Gender Equality.

уламжлагдан тогтсон жендэрийн үнэт зүйл, хэм хэмжээ, хэвшмэл үзлээр тодорхойлогддог ч цагийн эрхээр, мөн өөр өөр соёлд өөрчлөгдсөөр ирсэн зүйл юм.

- **Жендэрийн хэм хэмжээ болон үнэт зүйл** нь эрэгтэй болон эмэгтэй хүмүүс ямар байх ёстой, юу хийх ёстой, юу хийж чаддаг талаарх ихэнх хүмүүсийн эсвэл хувь хүний үзэл төсөөлөлтэй холбоотой. Жишээлбэл, ихэнх нийгэмд эмэгтэйчүүдийг үзэсгэлэнтэй, дуулгавартай сайн гэрийн эзэгтэй байх ёстой, харин эрэгтэйчүүдийг хүчтэй, зоригтой, гэр бүл, нийгэмдээ манлайлагч байх ёстой гэж үздэг.
- **Жендэрийн тухай хэвшмэл үзэл** (ташаа ойлголт) бол эрчүүд болон эмэгтэйчүүдийн чадвар чадавхын талаар хүмүүст тогтсон үзэл бодол юм. Жишээлбэл, эмэгтэйчүүд сайн удирдагч байж чаддаггүй, харин эрэгтэйчүүд сайн сувилагч байж чаддаггүй. Хэвшмэл үзэл нь заримдаа үнэн байж болох ч бодит баримт болон логикт суурилагагүй байдгийн улмаас ихэнх тохиолдолд буруу ташаа байдаг. Хэвшмэл үзэл нь ихэнхдээ үндэслэлгүй бөгөөд шударга бус байдаг.

Жендэрийн үүрэг, хэм хэмжээ бидэнд хэрхэн нөлөөлдөг вэ?



Аль ч нийгэмд жендэрийн үүрэг, үнэт зүйл, хэм хэмжээ нь хүмүүсийн амьдралд нөлөөлж байдаг. Жендэрийн үүрэгт бид суралцдаг. Учир нь энэ бол төрмөл биш, заяагдмал биш. Хүүхдүүд гэр бүлээсээ жендэрийн үнэт зүйл, хэм хэмжээг ажиглаж, өөртөө шингээж байдаг бөгөөд хүүхэд асрах, гэрийн ажил хийх, гадаах ажлаа хариуцах, шийдвэр гаргах зэрэгт эрчүүд/хөвгүүд болон эмэгтэйчүүд/охидын үүрэг хариуцлага өөр өөр байгааг анзаарч, суралцаж эхэлдэг. Зарим гэр бүлд охид, хөвгүүдэд адилхан хандаж, сурч боловсрох боломжоор тэнцүү хангаж, гэрийн ажлаа адилхан хуваан хийлгэдэг

ч айл бүрд ийм байдаггүй нь үнэн билээ.

Ихэнх нийгэмд охид хөвгүүд, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эдлэх эрх, боломж бололцоо ялгаатай байдаг. Хамгийн нийтлэг ялгаа нь сурч боловсрох, ажлын ачааллыг хуваарилах, ямар нэгэн нөөц боломж болон үр шимээс хүртэх, шийдвэр гаргах эрхээ эдлэх хүрээнд илэрдэг.

Жендэрийн үүрэг өөрчлөгдөх боломжтой юу?

Жендэрийн талаарх ойлголт төсөөлөл нэг соёл (эсвэл нийгэм)-оос нөгөө соёлд харилцан адилгүй байдаг. Жендэрийн ялгаатай байдалд хүмүүс бага наснаасаа эхлэн суралцаж байдаг тул гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлага зэрэг жендэрийн ялгааг ихэнх хүмүүс хэвийн зүйл мэт хүлээж авдаг. Жендэрийн ялгаатай байдал нь биологи болон байгалийн нөлөөгөөр үүсэж бий болдоггүй, харин цаг хугацааны эрхээр тухайн нийгэмд амьдарч буй хүмүүсийн санаа бодлоор биеллээ олж байдаг бөгөөд ялангуяа залуу хүмүүсийн дунд эдгээр санаа өөрчлөгдөх боломжтой ба өөрчлөгдөж ч байдаг. Өнгөрсөн цаг үетэй харьцуулахад өнөөдөр жендэрийн тэгш байдал илүү хэрэгжсээр байна. Аль ялгааг нийгэм, хүмүүс өөрсдөө бий болгосон, харин аль ялгаа нь биологийн хүчин зүйлээр тодорхойлогддог болохыг ялгах нь чухал юм. Тухайлбал, эрчүүд хүчтэй тул уйлах ёсгүй гэсэн санааг нийгэм бий болгосон бол эмэгтэй хүн хүүхэд төрүүлэх нь биологийн шинж чанартай ойлголт юм. Хатуу чанга жендэрийн хэм хэмжээнээс охид, хөвгүүд аль аль нь сөрөг үр дагавартай учирч болно. Илүү тэгш байдал болон илүү уян хатан жендэрийн үүрэг хариуцлага нь хүн бүрт өөрийн чадварыг бүрэн хөгжүүлэх илүү их боломжийг олгох болно.

Жендэрийн хэм хэмжээ яагаад хор хөнөөлтэй байж болох вэ?

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын эрх мэдлийн харьцаа нь тэдний амьдралын бүхий л салбарт, тэр дундаа нийгэм, улс төр, эдийн засгийн үүрэг, амьдралын хэв маягт нь нөлөөлдөг. Охидыг ихэвчлэн өөрийгөө мэдэх эрх бараг олголгүйгээр өсгөдөг бол хөвгүүдийг “эр муу ч эмийн дээр” хэмээн сургаж өсгөдөг. Гэхдээ олонх хүүхдүүд жендэрийн хэвшмэл үзэлд баригдалгүйгээр өсөж хөгждөг. Жишээлбэл, охид спортод дурлан хичээллэж, тооны хичээлдээ шамдан, эх орноо хөгжүүлэх удирдагч болохоор тэмүүлэхийн хамт эмэгтэйлэг гэдгээ мэдэрч байхад хөвгүүд бие биетэйгээ дотно нөхөрсөг харилцаж, урлагийг сонирхон, эр хүн бол байнга амжилттай, бас зоригтой байх ёстой гэсэн дарамт шахалтаас ангид байхын зэрэгцээ эрэгтэйлэг байдлаа мэдэрч чаддаг.

Гэр орны өдөр тутмын ажил үүргүүд хүний амьдралын чухал хэсэг мөн боловч түүнд оролцдоггүй хүмүүс үүнийг зохих ёсоор үнэлэхгүй, анзаарахгүй өнгөрөх нь элбэг. Мэдээж эрчүүд, эмэгтэйчүүдийн хэн хэн нь гэр орны ажил хийх чадварыг адилхан эзэмшсэн байдаг ба байгалиасаа эмэгтэй хүн л гэрийн ажил хийхдээ сайн гэсэн зүйл огт байхгүй. Хандлагын энэ мэт ялгаа нь эрэгтэй болон эмэгтэй хүний тухай нийгэмд уламжлагдан тогтсон төсөөллөөс үүдэлтэй бөгөөд энэ замаар л бид эрэгтэй болон эмэгтэй хүн болон өсдөг.

Хатуу тогтсон жендэрийн үүрэг, хэм хэмжээ нь хүмүүсийн бие биетэйгээ харилцах харилцаанд нөлөөлж, зарим тохиолдолд хүчирхийлэл, амиа хорлох үйлдэл хийх гэх мэт нийгмийн олон асуудал руу хөтөлдөг тал бий. Эсрэг хүйсийнхээ хүнтэй л гэрлэх ёстой гэх хатуу тогтсон хэм хэмжээнд баригдах боломжгүй хүмүүс нийгэмд байнга хавчигдаж, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, хууль ёсны эрхээ эдлэх гэх мэт нийгмийн харилцааны олон талбараас гадуурхагддаг. Иймэрхүү хүндлэлгүй харилцаа үүсэх нь тэднийг хүсээгүй харилцаа руу түлхдэг бөгөөд бэлгийн хүчирхийлэл болон ХДХВ, БЗДХ зэрэгт өртөх, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт зэргийг сонгох нөхцөлийг бүрдүүлдэг. Тодруулбал, ижил хүйстнээ сонирхогч, эмэгтэйлэг төрхтэй хөвгүүд, эмэгтэйлэг бус гэгдэх охид, мөн мэргэжлийн спортын тамирчин охид зэрэг жендэрийн хэм хэмжээнд нийцээгүй хүмүүс гутаан доромжлол, гадуурхал, заналхийлэлд өртөх нь элбэг байдаг.

Жендэрийн тэгш байдлын төлөө ажиллах нь яагаад чухал вэ?

Хүн бүр бүхий л салбарт өөрийн авьяас чадвараа хөгжүүлж, ашиглаж чадаж байвал хүн бүрд хэрэгтэй. Бидний амьдарч буй нийгэм, соёл байнга хувьсан өөрчлөгдөж байдгийг санаж байх нь чухал. Хүмүүсийн амьдрах орчин нөхцөл заримдаа сайн тал руу, заримдаа муу тал руу өөрчлөгдөх нь бий. Жендэрийн үүргүүд ч хувьсан өөрчлөгдөж байдаг:

- **Жендэрийн тэгш байдал** гэдэг нь ажил амьдрал дээр хөвгүүд охид, эрэгтэй эмэгтэй хэмээн ялгалгүйгээр хүн бүрд тэгш эрх, үүрэг, хариуцлага, боломж олгохыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, хүйсээс үл шалтгаалан мэдээлэл хүртэх, сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, шийдвэр гаргах, гэр бүлийн болон нийгмийн баялгаас (хоол хүнс, мөнгө, газар г.м.) хүртэх, нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авах, хүндлүүлж харилцах тал дээр адил тэгш эрх эдэлнэ гэсэн үг юм. Хүн бүр ялгаварлалгүй шударга, адил тэгш байдлаар нөөц баялгаас хүртэх, хуваарилалтад хяналт тавих, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах, шийдвэр гаргахад оролцох эрхтэй.



- **Жендэрийн**

эмэгтэй хэмээн

ялгаварлалгүйгээр боломжийг адил тэнцүү олгож, үр дүнг адил тэнцүү хүртэх, хүн ёсоор хүндлүүлж, хайрлуулах, өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж, бүх хүний амьдралын чанарыг сайжруулах явдал юм. Энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүс яг адил болно гэсэн үг огт биш. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр байж болох ч амьдралдаа хүлээх үүрэг хариуцлага, эдлэх эрх, оногдох боломжийн хувьд тэгш байна гэсэн үг билээ. Хөвгүүд охид, эрэгтэй эмэгтэй хэмээн ялгаварлалгүй адилхан харилцаж, хийсэн ажлыг нь эрэгтэй, эмэгтэй хэмээн ялгалгүй шударгаар үнэлж байх нь хамгийн чухал. Иймд, хүнийхээ хувьд, ажилтныхаа хувьд хүйсийн ялгаваргүй адил тэнцүү эрх эдэлж, хийсэн ажлаа шударгаар үнэлүүлж:

- үүрэг хариуцлага болон боломж,
- ажлын ачаалал болон орлого хуваарилалт, шийдвэр гаргах явц зэрэгт зүй зохистой, шударга оролцоотой байх нөхцөл бий болсон цагт л **Жендэрийн тэгш байдал** хангагдлаа гэж үзнэ.

Жендэрийн тэгш байдлыг дэмжихэд чиглэсэн үндсэн санаа

Жендэрийн тэгш байдлыг дэмжих тухай сургалтын явцад сургагч багш нар дараах Түлхүүр мэдээллийг заавал тайлбарлаж өгснөөр сургалт үр өгөөжтэй байх болно. Үүнд:

- **Жендэрийн тэгш байдлыг хангах нь нийгмийн гишүүн бүрийн үүрэг хариуцлага юм.** Гэр

бүл болон нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагын тухай нэгдмэл бөгөөд тэнцвэртэй ойлголт бий болж, гэр бүл, ажлын байранд, нийгмийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангах талаар үе үеийнхний хооронд зөвшилцөлд хүрэх хэрэгтэй. Жендэрийн тэгш байдлыг дэмжихэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэн хэнийх нь оролцоо чухал.



- **Жендэрийн тэгш байдлыг дэмжих нь нийгмийн гишүүн бүрд ач холбогдолтой.** Эмэгтэй хүний байр суурь дээшлэх нь зарим эрчүүдийн хувьд айдас авчрах нь бий. Гэхдээ жендэрийн тэгш байдлыг дэмжинэ гэдэг нь эрчүүдийн эрх мэдлийг хагасалж, эмэгтэйчүүдийг илүү эрх мэдэлтэй болгоно гэсэн үг биш юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлыг дэмжсэнээр харин ч хоёр хүйсийн хувьд хэн хэндээ ашигтай нөхцөл бүрддэг.



- **Жендэрийн тэгш байдлыг дэмжих нь зөв зүйл төдийгүй мөн ухаалаг алхам юм.** Хөгжлийн үйл

явцад эрэгтэй, эмэгтэй хүн бүрийг ижил тэгшээр татан оролцуулах нь шударга бөгөөд зүй ёсны үзэгдэл билээ. Учир нь гэр бүл, нийгэм дэх бүхий л нөөц боломж, авьяас чадварыг ашиглах нь эдийн засаг бизнесийн хувьд ч зөв алхам болох нь тодорхой.

Жендэрийн тэгш байдлын асуудлыг илүү гүнзгий ойлгохын тулд: (В. Жендэрийн тэгш байдлын стратеги, Г. Хүйсийн баримжаа ба бэлгийн чиг баримжаа, Д. Ялгаварлан гадуурхалт)-тай танилцана уу.

Дасгал 3.1.2 Бодит баримт уу эсвэл үзэл бодол уу?



Зорилт

Хүйс болон жендэрийн үүргийн талаарх бодит баримт болон үзэл бодлын ялгааг ойлгох



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид (хүүхдийг залуучууд, насанд хүрэгчдээс тусад нь оролцуулна)



Хугацаа

60 Минут



Суудал зохион байгуулалт

Хүүхдүүд оролцож байгаа бол зай ихтэй талбайд хагас тойрог болон сууна. Залуучууд болон насанд хүрэгчдийн хувьд багаар ажиллах байдлаар сууна.



Ашиглах материал

Самбарын цаас, самбарын үзэг, цаасан скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

3.1.2 А: Бодит баримт уу эсвэл үзэл бодол уу?

3.1.2 Б: Бодит баримт ба үзэл бодлыг тэмдэглэх хуудас

Нэмэлт мэдээлэл: Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон тодорхойлолтууд (Дасгал 3.1.1)



Сургалт зохион байгуулах алхмууд ⁵

1. Бодит баримт, үзэл бодлын ялгаа – 5-10 минут
2. Бодит баримт гэж юу вэ, үзэл бодол гэж юу вэ? – 10 минут
3. “Бодит баримт уу, үзэл бодол уу?” тоглоом – 20-25 минут
4. Задлан шинжиж, дүгнэх – 20 минут

⁵ Эх сурвалж: *World Wise School* by Peace Corps, Part 2: Developing Global Perspectives, Is That a Fact?, <http://files.peacecorps.gov/uploads/www/lesson-plans/files/looking.fact.a.pdf>.

Бэлтгэл

Сургалтын хэрэглэгдэхүүн 3.1.2 А: "Бодит баримт уу эсвэл үзэл бодол уу?"-г анхааралтай уншиж, "бодит баримт" болон "үзэл бодол" гэсэн ойлголтыг сайн ойлгосон эсэхээ хянаарай. Түүнчлэн Сургалтын хэрэглэгдэхүүн 3.1.2 Б дээр бие даан ажиллаж, өгөгдөл нь бодит баримт эсвэл хувийн үзэл бодол эсэхээс үл хамаарч өгөгдөл бүрийг ойлгосон эсэхээ шалгаарай. Алхам 2-г хийхийн өмнө хүүхдэд зориулсан эсвэл залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан дасгалын алийг нь хийхээ сонгож, бэлдэх хэрэгтэй. Хэрэв оролцогчид нь хүүхдүүд бол Алхам 1-т 10 минут зарцуулахад болно. Харин оролцогчид нь залуучууд, насанд хүрэгчид байвал Алхам 1-т 5 минутаас илүүгүйг зарцуулж, Алхам 3-т арай урт хугацаа төлөвлөөрэй.

Алхам 1. Бодит баримт ба үзэл бодлын ялгаа – 5-10 минут

Оролцогчдод бодит баримт ба үзэл бодлын ялгааг танилцуулаад, бодит баримтыг илэрхийлсэн 3 жишээ, хувийн үзэл бодлыг илэрхийлсэн 3 жишээ самбарт бичээрэй (аль болох оролцогчдын амьдралд ойр жишээ авахыг хичээгээрэй). Ингэхдээ аль нь бодит баримт, аль нь үзэл бодол болохыг хэлэхгүй, харин оролцогчдоос өөрсдөөс нь асууна. Жишээ нь:

1. Ази хүмүүс хар үстэй байдаг. (ББ)
2. Ази хүмүүс их гоё үстэй. (ҮБ)
3. Манай сургуульд багш дутагддаг. (ҮБ)
4. Манай сургууль 4 багштай. (ББ)
5. Тооны хичээл их уйтгартай. (ҮБ)
6. Би тооны сүүлийн шалгалтаар 65 оноо авсан. (ББ)

Оролцогчид аль өгөгдөл нь бодит баримт, харин аль нь хувийн үзэл бодол болохыг тодорхойлно.

Оролцогчид хариулж дууссаны дараа дээрх жишээг дараах байдлаар байрлуулж үзүүлээрэй:

Бодит баримт (ББ)	Үзэл бодол (ҮБ)
1. Ази хүмүүс хар үстэй байдаг.	1. Ази хүмүүс их гоё үстэй.
2. Манай сургууль 4 багштай.	2. Манай сургуульд багш дутагддаг.
3. Би тооны сүүлийн шалгалтаар 65 оноо авсан.	3. Тооны хичээл их уйтгартай.

Алхам 2. Бодит баримт гэж юу вэ, үзэл бодол гэж юу вэ? – 10 минут

Оролцогчдоос дараах асуултыг асууж, "бодит баримт" ба "үзэл бодол"-ын тодорхойлолтын талаар санаа цуглуулаарай:

1. Тухайн өгөгдөл бодит баримт гэдгийг хэрхэн таних вэ?
2. Тухайн өгөгдөл хувийн үзэл бодол гэдгийг хэрхэн таних вэ?
3. Бодит баримт болон үзэл бодлын ялгаа нь юу вэ?
4. Хэрэв тухайн өгөгдөл бодит баримт болон үзэл бодлын аль нь болохыг мэдэхгүй бол та яах вэ?
5. Яагаад бодит баримт болон үзэл бодлыг ялгаж сурах нь чухал вэ?



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Сургагч багш та Алхам 2-г тайлбарлахын өмнө өөрөө бодит баримт болон үзэл бодлын тухай зөв ойлголттой байх ёстой. Иймд Сургалтын хэрэглэгдэхүүн 3.1.2.А-г сайтар уншиж ойлгоод, дээрх асуулт тус бүрийг тайлбарлах чадвартай болсон байх хэрэгтэй. Товчоор хэлбэл:

- **Бодит баримт** бол нотолгоотой бөгөөд хэн ч гуйвуулж чадахгүй, бүх хүний хүлээн зөвшөөрдөг баримт юм.
- **Үзэл бодол** бол аливаа асуудлын талаарх хүмүүсийн үзэл, мэдрэмж, итгэл үнэмшил бөгөөд бодит баримтаар нотлогдоогүй байдаг. Үзэл бодол нь субъектив шинжтэй бөгөөд нэг л зүйлийн талаар өөр өөр хүмүүс өөр өөр үзэл бодолтой байж болно.

Алхам 3. “Бодит баримт уу, үзэл бодол уу?” тоглоом – 20-25 минут

Хүүхдүүдэд: Сургалтын хэрэглэгдэхүүн 3.1.2 Б дотроос 20 өгөгдлийг дугаартай нь урьдчилан хэвлэж бэлдэнэ. Өгөгдөл бүрийг хуйлж, хайрцагт хийнэ.

- Хүүхдүүд нааш цааш гүйлдэж болохоор зай гарган өрөөгөө бэлдэнэ.
- Сайн дураараа 3 хүүхэд гарч ирэхийг хүсээд, эхний хүүхдийн энгэрт **“БОДИТ БАРИМТ”**, дараагийн хүүхдэд **“ҮЗЭЛ БОДОЛ”**, сүүлийн хүүхдэд **“МЭДЭХГҮЙ”** гэсэн бичигтэй цаас наана. Тэдгээр хүүхдүүдийг өөр өөр буланд зогсооно.
- Бусад хүүхдийг нэг нэг хуйлмал сугалж авахыг хүсээрэй (бүх хүүхдэд хүрэлцэхгүй байж болно).
- 1 дугаартай жишээ сугалсан хүүхдийг жишээгээ бусдад сонсогдохуйц чангаар уншиж өгөхийг хүснэ. Уг жишээ бодит баримт, үзэл бодлын аль нь болохыг оролцогчид шийдэж, тохирох тэмдэгтэй гурван хүүхдийн аль нэгний хажууд очиж зогсоно.
- Дараа нь 2 дугаартай жишээ авсан хүүхэд жишээгээ танилцуулах байдлаар 20-р жишээ хүртэл хэлэлцэнэ.
- Өгөгдөл бүр дээр яагаад үүнийг бодит баримт эсвэл үзэл бодол гэж бодож байгаа шалтгааныг хүүхдүүдээс асууна. Хүүхдүүдийн санал зөрөлдсөн тохиолдолд нөгөө талаа ятган үнэмшүүлэхийг дэмжээрэй.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Сайн уншиж сураагүй хүүхдүүд байвал хамгийн сайн уншдаг 1-2 хүүхдийг сонгон уншуулах, эсвэл сургагч багш өөрөө чангаар дуудан уншиж өгч болно. Хангалттай хугацаа байгаа эсэх, эсвэл хүүхдүүдийн хүлээн авах чадвар зэргээс шалтгаалан 10-15 жишээ сонгох, эсвэл Зорилтот бүлэгт тохируулан өөр жишээ оруулах боломжтой. Түүнчлэн, залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан дасгалын үеэр ч жишээнүүд нь бодит амьдралд илүү ойр байх нь зүйтэй. Дасгалын гол зорилго нь нийгэмд түгээмэл байгаа хүйсийн үүргийн тухай ойлголт, үзлийг задлан шинжих чадварыг оролцогчдод хөгжүүлэхэд оршино.

Залуучууд, насанд хүрэгчдэд: Хэрэв оролцогчид бичиг үсэгт тайлагдаагүй бол хүүхдүүдэд дасгал ажиллуулсантай адил ажиллаж болно. Эсвэл дараах алхмын дагуу ажиллаарай:

- Оролцогчдыг 4-6 хүнтэй холимог багуудад хуваана.
- Баг бүрд Сургалтын хэрэглэгдэхүүн 3.1.2 Б-г тарааж, самбарын цаас болон самбарын үзэг өгнө.
- Багууд дотроо харилцан ярилцаж, аль өгөгдөл нь бодит баримт эсвэл үзэл бодол болохыг шийдэх ба шийдэхээсээ өмнө нэмэлт мэдээлэл хэрэгтэй эсэхийг ярилцаж болно. Хоорондоо ярилцахад нь 15-20 минут өгөх ба хариултаа цаасан дээр буулгаж танилцуулгаа бэлдэхэд нь зориулж 5 минут өгнө.
- Багууд даалгавраа дуусмагц хариултаа нийтэд танилцуулахыг хүснэ. Сургагч багш бүх багийн самбарын цаасан дээрх хариултуудыг харьцуулан хэлэлцүүлэг өрнүүлнэ. Багуудын ижил төстэй болон ялгаатай талыг онцлон, бүгд санал нийлж байгаа эсэх, зарим нэг өгөгдөл дээр нэмэлт мэдээлэл хэрэгтэй байсан эсэхийг асуугаарай.

Алхам 4. Задлан шинжилж, дүгнэх – 20 минут

Жишээнүүдээс эхлээд бодит баримтыг ялган шинжилнэ (**Түлхүүр:** 2, 4, 12, 14, 16, 18-р өгөгдлүүд бол бодит баримт). Дараа нь үлдсэн өгөгдлийг шинжлэн ярилцана.

Юуны өмнө бодит баримт болон үзэл бодлын ялгааг онцолж, жендэрийн үүрэг, үнэт зүйл, хэм хэмжээ болон хэвшмэл үзлийн талаарх ташаа, эерэг болон сөрөг үзэл бодлыг **тодруулан, нууцыг нь тайлж** өгөх хэрэгтэй (Дасгал 3.1.1-т байгаа Нэмэлт мэдээлэл: Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон тодорхойлолтуудыг уншаарай). Хүйсийн тухай хэвшмэл үзэл, ташаа ойлголтод суурилсан өгөгдлийн жишээ татаж, эдгээр нь бодит баримтад тулгуурлаагүй ойлголт, үзэл бодлоос үүдэлтэй болохыг тайлбарлана. Ийм үзэл бодлыг нийгмийн ихэнх хэсэг нь бодит үнэн хэмээн хүлээн зөвшөөрвөл нийгэм ч тэр, хувь хүн ч тэр хохирох болно. Жишээ нь:

- Охид нэгэнт гэрлэхээс хойш сурч боловсрох шаардлагагүй хэмээн эцэг эхчүүд, нийгэм нь тэр даяараа үздэгээс болж олон охид хангалттай боловсрол эзэмшиж чаддаггүй.
- Архи уух, согтох нь эр хүнд байх л үзэгдэл хэмээн нийгмийн зүгээс ханддагаас олон эрчүүд бага залуу наснаасаа архи хэрэглэж, түүндээ донтох болсон. Архи ууж, согтуурхдаг эрчүүдийн ихэнх нь ажилгүй, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч байх нь түгээмэл байдаг.

Дараах гол санааг багцлан дасгалыг дуусгана:

- **Бодит баримтыг** баталж нотолж болох бөгөөд хүн бүр үүнтэй санал нэгддэг.
- **Үзэл бодол** гэдэг нь аливаа асуудлын талаарх хүмүүсийн үзэл, мэдрэмж, итгэл үнэмшил бөгөөд бодит баримтаар нотлогдоогүй байдаг.
- Хүйсийн үүргийн талаарх үзэл бодол болон ташаа ойлголт нь нийгэмд байсаар ирсэн бөгөөд энэ нь хүйсийн тэгш бус байдлыг үүсгэж, түүний оршин тогтнох суурь нь болдог.
- Өдөр тутмын амьдралдаа авч байгаа мэдээллээ бид байнга шинжиж үзэх хэрэгтэй байдаг.
- Ямар нэгэн мэдээллийг бодит үнэн эсэхийг ялгаж сурах нь зөв шийдвэр гаргахад хамгийн тустай. Хуурамч мэдээнд итгэж, буруугаар ойлгож, буруу таамаглал, буруу шийдвэр гаргаснаас мэхлэгдэх, алдаа гаргах, бусдыг гомдоох, өөрийгөө эвгүй байдалд оруулах зэрэг олон эрсдэл тулгарч болно.
- Иймд, ямар нэгэн мэдээлэлд итгэхээсээ өмнө нэмэлт мэдээлэл хайж, үнэн бодит эсэхийг нь магадалж, бодит баримт, үзэл бодлын ялгааг таньж сурах нь чухал юм.



Сургалтын хэрэглэгдэхүүн 3.1.2 А: Бодит баримт уу, үзэл бодол уу?

1. Тухайн өгөгдөл бодит баримт гэдгийг хэрхэн таних вэ?

Тухайн өгөгдлийг баримтаар нотлох боломжтой бөгөөд, гуйвуулж болохгүй бол бодит үнэн байдаг. Жишээ нь $2 + 2 = 4$; зөвхөн эмэгтэй хүн л хүүхэд төрүүлдэг г.м. Өөрөөр хэлбэл 2 дээр 2-г нэмбэл зөвхөн 4 болно; дэлхий дээр зөвхөн эмэгтэй хүн л байгалиасаа хүүхэд төрүүлэх чадвартай байдаг.

2. Тухайн өгөгдөл үзэл бодол гэдгийг хэрхэн таних вэ?

Үзэл бодол гэдэг нь хувь хүний эсвэл бүлэг хүмүүсийн мэдрэмж эсвэл итгэл үнэмшил бөгөөд бодит баримтад суурилаагүй, баталгаа нотолгоогүй байдаг. Жишээлбэл. Баян хүмүүс аз жаргалтай амьдардаг. Гэвч энэ нь үнэн ч байж болно, худал ч байж болно. Үүнийг баримтаар нотолж ч болно, үгүйсгэж ч болно. Гэхдээ нотлоход хэцүү үзэл бодол байдаг. Жишээ нь: диваажин, үхлийн дараах амьдрал, дахин төрөлт г.м.

3. Бодит баримт болон үзэл бодлын ялгаа нь юу вэ?

Үзэл бодол субъектив шинжтэй бөгөөд бодит баримтад түшиглэдэггүй. Нэг л зүйлийн талаар хүмүүс өөр өөр үзэл бодолтой байж болно. Жишээ нь: мотоцикл унахын тухайд хүмүүс янз бүрийн үзэл бодолтой. Заримынх нь хувьд зугаатай, түргэн, тухтай, сонирхолтой байдаг бол нөгөө нэгэнд нь аюултай санагддаг. Харин заримд нь ямар ч ялгаагүй, эсвэл энэ талаар ямар нэгэн үзэл бодолгүй байдаг. Хэрэв үзэл бодол нь мэдрэмжтэй холбоотой байвал заавал зөв эсвэл буруу байх албагүй бөгөөд зүгээр л өөр өөр гэсэн үг. Харин нотолгоо баталгаатай үнэн зүйлийг бодит баримт хэмээн хүн бүр хүлээн зөвшөөрдөг. Жишээ нь: $2+2 = 4$; эмэгтэй хүн л хүүхэд төрүүлдэг болохыг г.м. Мотоцикл 2 дугуйтай гэдгийг бүгд мэддэг, хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ энэ бодит байдал нь цаг хугацаа, нөхцөл байдлаас хамаараад өөрчлөгдөж болдог. Нисэх онгоц гарахаас өмнө галт тэрэг хамгийн хурдан унаанд тооцогдож байсан эсвэл хүүхэд зөвхөн эхийн умайд бүрэлддэг байсан бол одоо лабораторид бий болдог болсон г.м.

4. Хэрэв тухайн өгөгдөл бодит баримт болон үзэл бодлын ал нь болохыг мэдэхгүй бол та яах вэ?

Энэ тухай илүү дэлгэрэнгүй мэдээлэл олж авахыг оролдож, баримт нотолгоо хайгаарай.

5. Тухайн өгөгдөл бодит баримт, үзэл бодлын аль нь болохыг мэдэж байх нь яагаад чухал вэ?

Өдөр тутмын амьдралд, бусадтай харилцах харилцаанд мэдлэг болон хүндлэл маш чухал байдаг. Ямарваа зүйлийг буруугаар ойлгох, буруугаар төсөөлөх зэргээс болж бид алдаа гаргах, бусдыг гомдоох, өөрийгөө болон бусдыг хохироох ч эрсдэлтэй. Жишээ нь: аадар борооны үеэр тал хээр газар байх нь аюулгүй гэсэн буруу ойлголттой хүн аянгад ниргүүлэх магадлалтай. Нэг тосгон эсвэл улсад амьдардаг хүмүүс бүгд муу хүмүүс гэсэн итгэлтэй хүн (эрүүл ухаантай хүн ийм байх боломжгүйг мэддэг) өөрийгөө болон бусдыг эвгүй байдалд оруулах үйлдэл гаргах магадлалтай.



Сургалтын хэрэглэгдэхүүн 3.1.2 Б: Бодит баримт ба үзэл бодлыг тэмдэглэх хуудас

Үнэн гэж үзсэн баганад (✓) тэмдэг тавинарай.

№	Өгөгдөл	Бодит баримт	Үзэл бодол	Нэмэлт мэдээлэл хэрэгтэй
1	Охид, эмэгтэйчүүд дөлгөөхөн, сайхан сэтгэлтэй, хайр татам байдаг.			
2	Эрчүүд гол төлөв эмэгтэй хүнээс өндөр, биерхүү байдаг.			
3	Эр хүн уйлдаггүй.			
4	Зөвхөн эмэгтэй хүн л жирэмсэлж, хүүхэд тээн төрүүлж чадна.			
5	Эмэгтэйчүүд хүүхэд хүмүүжүүлэхдээ эрчүүдээс илүү сайн.			
6	Гэрийн ажил бол эмэгтэйчүүдийн хийх ажил учир хөвгүүд гэрийн ажил хийх хэрэггүй.			
7	Хөгширсөн хойно нь эцэг эхээ хөвгүүд л асардаг учир охидоос илүү чухал.			
8	Нэгэнт гэрлэхээс хойш охид дээд боловсрол эзэмших шаардлагагүй.			
9	Эрчүүд бусдыг удирдахдаа эмэгтэйчүүдээс илүү сайн.			
10	Эрчүүд эмэгтэйчүүдээс илүү шийдэмгий байдаг.			
11	Эмэгтэйчүүд эрчүүдээс илүү шударга байдаг.			
12	Жирэмсэн эмэгтэй хүнд хүчир ажил хийж, архи ууж, мансууруулах бодис хэрэглэж болохгүй, учир нь энэ бүхэн хүүхдэд нь халтай.			
13	Хүү төрөхгүй байгаа бол эхнэрийн буруу.			
14	Хүүхдийн хүйсийг аавынх нь Y хромосом тодорхойлдог.			
15	Эр хүний хамгийн чухал үүрэг бол удирдагч байж гэр бүлээ тэжээх, харин сайн ээж, сайн эхнэр байх нь эмэгтэй хүний гол үүрэг юм.			
16	Дэлхий даяар сургуулиас завсардсан охидын тоо хөвгүүдийнхээс их байна.			
17	Эмэгтэйчүүд хоол хийхдээ эрчүүдээс илүү сайн.			
18	Олон улс оронд адилхан ажил хийсэн ч эрчүүд эмэгтэйчүүдээс илүү өндөр цалин хөлс авдаг.			
19	Эрчүүд өрх гэрээ тэжээгчид учир эмэгтэйчүүдээс илүү цалин авах нь зүй ёсны хэрэг юм.			
20	Эрэгтэй хүн согтож болно, харин эмэгтэй хүн согтох нь муухай харагддаг.			

Сэдэв 3.2 Жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл ба хандлага



Агуулга

Энэхүү сэдвийн хүрээнд гэр бүл, нийгэм дэх жендэрийн үүрэг, хандлагын талаар хэлэлцэнэ. Ингэснээр оролцогчид эрэгтэй, эмэгтэй хүн, охид хөвгүүдийн талаарх нийгэмд ноёрхож байгаа хандлага, үнэт зүйлийг судлах боломжтой. Улмаар нийгмийн шударга ёсыг сахиулах, охид хөвгүүдийг тэгш боломжоор хангах, өөрсдийн сонголтоо хийх боломж олгох нь чухал тул эдгээр үнэт зүйл болон хандлагын алийг нь авч үлдэж, алийг нь өөрчлөх шаардлагатай болохыг тодорхойлох болно.



Үндсэн мэдээлэл

- Нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүн, охид хөвгүүд ямар байх хэрэгтэй, юу хийж болох ба болохгүй, яах хэрэгтэй хэрэггүй гэх асуудлаар өөр өөр хандлага, үнэт зүйл, төсөөлөлтэй байдаг. Эдгээр үнэт зүйл болон хандлага нь хүмүүсийн сэтгэлгээ, зан үйл, амьдрал ахуйд нь нөлөөлдөг байна.
- Жендэрийн үүргийн талаарх үзэл бодол нь өөр өөр соёлд, нэг соёлын хүрээнд ч ялгаатай байдаг. Цаг хугацаа өнгөрч, нийгэм өөрчлөгдөхийн хэрээр үзэл бодол, хандлага нь өөрчлөгдөж байдаг.
- Хөвгүүд болон охидын талаарх эцэг эх болон нийгмийн ялгавартай төсөөлөл, хүлээлт нь тэдний амьдралд маш их нөлөөлдөг. Энэхүү хүлээлт нь хүүхдэд шууд ба шууд бусаар дарамт болж, тэднийг өөрөөрөө байж чадахгүй, ямарваа сонголтыг өөрийн хүслээр бус эцэг эх, нийгмийн шахалт дор хийхэд хүргэдэг.
- Бүх хүүхэд өөрсдийнхөө ирээдүйг өөрсдөө төлөвлөж, сонголтоо өөрсдөө хийх эрхтэй. Ийм учраас хүүхдийг эрэгтэй эмэгтэй гэдгээр нь ялгалгүйгээр тэдэнд адил боломж олгож, бүхий л авьяас чадвараа бүрэн дүүрэн ашиглахыг нь дэмжих нь зүйн хэрэг юм.



Дасгалууд

3.2.1 Хэрэв би ... байсан бол ...

3.2.2 Цагийн хүрд



Холбогдох сэдвүүд

1.2 Миний гэр бүл ба миний орон нутаг

3.1 Хүү, охин байхын ялгаа нь юу вэ?

3.3 Гэр бүлээ аз жаргалтай байлгах нь

4.1 Гэр бүлд хэн нь юу хийдэг вэ, хэн нь үгээ хэлдэг вэ?

6.2 Хайр сэтгэл ба гэрлэлт

Дасгал 3.2.1 Хэрэв би ... байсан бол



Зорилго

- Жендэрийн үүргийн талаарх өөрийн хандлагаа таних
- Өөрийн гэр бүл, орчин тойрондоо давамгайлж буй жендэрийн үүргийн талаарх хандлагыг шинжих
- Охид, хөвгүүдэд шударга, тэгш боломж олгохын тулд юуг өөрчлөх хэрэгтэй байгааг тодорхойлох



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд



Хугацаа

45-60 Минут



Суудал зохион байгуулалт

Нийтээрээ ярилцах үедээ хагас тойрог хэлбэрээр суух ба багийн ажлын үеэр баг багаараа сууна.



Ашиглах материал

Самбарын цаас болон самбарын үзэг



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Хэрэв би ... болж төрсөн бол...: Багийн ажил – 5-10 минут
2. Охид, хөвгүүдийн амьдралын замнал – 10-15 минут
3. Охид, хөвгүүдийн амьдралын замналыг хуваалцах – 15-20 минут
4. Боломж болон хүлээлт – 10-20 минут
5. Дүгнэлт – 5 минут

Алхам 1. Хэрэв би ... болж төрсөн бол...: Багийн ажил – 5-10 минут

Нэг багт 4-6 ижил хүйсийн хүн байхаар багууд бүрдүүлнэ. Хамгийн багадаа охидын 2 баг, хөвгүүдийн 2 баг бүрдүүлнэ.

- Баг бүрд хүүхэд төрөх үеэс нас бие гүйцэх хүртэлх амьдралын замыг дүрсэлж, амьдралын чухал үйл явдлуудыг онцлон тэмдэглэх даалгавар өгнө.
- Хүүхэд төрөх, сургуульд орох, насанд хүрээд бие даан амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх, гэрлэх гэх мэт амьдралын чухал үйл явдлыг тусгасан, амьдралын замналын жишээ дүрсэлж харуулаарай (хэт их нуршиж олон жишээ дурдахаас сэргийлээрэй).

Баг бүрд дараах 4 даалгавраас нэгийг хуваарилаарай.

- Даалгавар 1: (охидын багт) Хэрвээ чи эрэгтэй хүүхэд болж төрсөн бол чиний амьдрал одоогоос юугаараа өөр байх байсныг төсөөлөөрэй. Ямар нэртэй байж болох талаар бодоод, бодит байдалд нийцэхээр амьдралын замналыг нь зураарай.
- Даалгавар 2: (охидын багт) Чи бол мөрөөдлөө биелүүлж чаддаг ид шидтэй охин. Мөрөөдлийн охиндоо нэр өгөөд, амьдралын замналыг нь дүрсэлнэ.
- Даалгавар 3: (хөвгүүдийн багт) Хэрвээ чи эмэгтэй хүүхэд болж төрсөн бол чиний амьдрал одооныхоос хэр их өөр байх байсныг төсөөлөөрэй. Ямар нэртэй охин байж болох талаар бодоод, бодит байдалд нийцэхээр амьдралын замналыг нь зураарай.
- Даалгавар 4: (хөвгүүдийн багт) Чи бол мөрөөдлөө биелүүлж чаддаг ид шидтэй хөвгүүн. Мөрөөдлийн хөвгүүндээ нэр өгөөд амьдралын замналыг нь дүрсэлнэ.

Алхам 2. Охид, хөвгүүдийн амьдралын замнал – 10-15 минут

Багуудад самбарын 1 цаас, 2-оос олон өнгийн самбарын үзэг тарааж өгөөрэй. Баг бүр:

- Төсөөлсөн охин эсвэл хөвгүүний амьдралын чухал үйл явдлуудын талаар ярилцана.
- Төсөөлсөн эмэгтэй эсвэл эрэгтэй хүүхдийн амьдралын чухал үйл явдлыг цаасан дээр зурсан амьдралын зам дээрээ тэмдэглэнэ. Амьдралын зам дугуй, мушгирсан, муруй гээд янз бүрийн хэлбэртэй байж болох ч тухайн охин/хөвгүүний амьдралын замыг хамгийн сайн илэрхийлэх нь чухал.
- Багийн нэг гишүүн багаа төлөөлөн даалгаврыг бусад багт танилцуулна.

Алхам 3. Охид, хөвгүүдийн амьдралын замналыг хуваалцах – 15-20 минут

Сондгой дугаартай даалгавар авсан багуудын (№1, №3) даалгаврын гүйцэтгэлтэй танилцсаны дараа бүх оролцогчдоос дараах асуултыг асуугаарай:

- Охин, хөвгүүний амьдралын замналын ижил болоод ялгаатай зүйлүүд юу вэ?
- Та бүгдийн төсөөлсөн эмэгтэй эсвэл эрэгтэй хүүхдийн амьдралын замнал нь охид хөвгүүдийн бодит амьдралыг тусгаж чадаж байна уу? Хэрвээ тийм бол яагаад тийм гэж? Харин үгүй бол яагаад?
- Төсөөлсөн охин эсвэл хөвгүүнтэй чинь адилхан хүнийг мэдэх үү? Хэн бэ?
- Энэ охин шиг, эсвэл хөвгүүн шиг амьдардаг гэж өөрийгөө боддог хүн байна уу?

Охин, хөвгүүний амьдралын замналтай танилцсан болохоор одоо дараагийн багууд мөрөөдлийн охин/хөвгүүний амьдралыг танилцуулна. Иймд тэгш дугаартай (№2, №4) даалгавар авсан багуудын даалгаврын гүйцэтгэлтэй танилцаад дараах асуултыг бүх оролцогчдоос асуугаарай:

- Бодит амьдрал дээрх охид, хөвгүүдийн амьдралын замнал болон мөрөөдлийн охид, хөвгүүдийн амьдралын замналын хоорондын ялгаатай болоод ижил талууд юу байна вэ?
- Энэхүү ялгаа болон ижил тал дээрх та нарын бодол ямар байна вэ?
- Мөрөөдлийн охин /хөвгүүн шиг амьдардаг хэн нэгнийг чи таних уу?
- Хэн, хэн энэ хөвгүүн/охин шиг амьдрахыг хүсэж байна вэ?

Алхам 4. Боломж болон хүлээлт – 10-20 минут

Доорх асуултаар дамжуулан дээрх дасгалаас ямар дүгнэлт гаргаж болох талаар оролцогчдоос асуугаарай.

- Гэр бүл болон нийгэм эрэгтэй, эмэгтэй хүүхдээс ижил хүлээлттэй байдаг уу?
- Хөвгүүдийн /охидын талаарх хүлээлттэй санал нийлж байна уу үгүй юу? Яагаад санал нийлж, яагаад санал нийлэхгүй байна вэ?
- Хэн нэгний урмыг хугалахгүйн тулд хийхийг хүсээгүй зүйл хийж байсан уу? Юуг, яагаад хийж байсан бэ?
- Гэр бүл болон нийгмийн зүгээс охидод /хөвгүүдэд/ хэрхэн хандвал шударга байх вэ?
- Үүнийг боломжтой болгохын тулд юуг өөрчлөх хэрэгтэй вэ?

Гэр бүлийн зүгээс хүүхдийнхээ амьдралд хэрхэн нөлөөлж болдгийг тайлбарлаж, эцэг эхчүүд нь охин хүү гэж ялгалгүйгээр хүүхдүүдээ хэрхэн тэгш боломж олгож болохыг онцолж тэмдэглэнэ. Жишээлбэл:

- Аюулгүй, эрүүл, хайр халамжаар дүүрэн орчинд хүү, охиноо өсгөн торниулж, аюул ослоос хамгаалах
- Хүү, охин хэмээн ялгалгүйгээр хүүхдүүдээ адилхан хайрлан хамгаалж, адил тэгш боломжоор хангах
- Гэр орны ажилд хүү, охин ижил үүрэг хариуцлага хүлээх ёстойг ойлгох, жишээ нь хүү нь охиных нь адил гэрээ цэвэрлэх
- Хүү, охины хэн хэн нь сургуульд сурахын ач холбогдлыг ойлгож, дээд боловсрол эзэмшихийг нь ч мөн дэмжих

Алхам 5. Дүгнэлт – 5 минут

Оролцогчдын дүгнэлтийг нэгтгэж, дасгал ажлаа дүгнээрэй:

- Хүүхдүүдийн амьдралд тэдний гэр бүл болон нийгмийн хүлээлт нөлөөлдөг. Энэхүү хүлээлт нь охид, хөвгүүдийн хувьд ялгаатай байдаг.
- Эдгээр хүлээлт нь шууд болон дам замаар хүүхдийг өөрөөрөө байж чадахгүй, ямарваа сонголтыг өөрийн хүслээр хийж чадахгүй байхад хүргэж болно.
- Бүх охид, хөвгүүдэд аюулгүй, эрүүл, хайр халамжаар дүүрэн орчин хэрэгтэй бөгөөд эрэгтэй, эмэгтэй гэдгээс нь үл хамааран тэднийг хүсэл зорилгодоо хүрэхэд ижил тэгш боломжоор хангах хэрэгтэй.
- Хүүхдийг өөрөө тунгааж, сонголтоо өөрөө хийхэд нь туслах хэрэгтэй.

Дасгал 3.2.2 Цагийн хүрд



Зорилго

- Өөрийн соёлын жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл, хандлагад дүн шинжилгээ хийх
- Цаг хугацааны явцад жендэрийн үүрэг болон үнэт зүйлс өөрчлөгдөж, өмнө нь хүлээн зөвшөөрөгдөж байсан үүрэг, үнэт зүйл нь өнөөгийн нийгэмд зохицохгүй байж болохыг ойлгох



Зорилтот бүлэг

Залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

45-75 минут



Суудал зохион байгуулалт

Нийтээрээ ярилцах үед хагас тойрог хэлбэрээр суух ба багийн ажлын үеэр баг багаараа сууна.



Ашиглах материал

- Самбарын цаас болон самбарын үзэг
- Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийг тодорхойлсон өөрийн болон бусад соёлын 10-20 зүйр болон хэлц үг
- Баг тус бүрд 5-6 ш. цаасан скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

Нэмэлт мэдээлэл: Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон тодорхойлолтууд (Дасгал 3.1.1)

Нэмэлт мэдээлэл: Жендэртэй холбоотой Монгол болон Зүүн Азид өргөнөөр хэрэглэдэг хэлц үгс



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Хэлц үгийг эвлүүлж тоглох – 15 минут
2. Хэлц үгийн утгыг ярилцах – 15-20 минут
3. Жендэртэй холбоотой урлагийн тоглолт – (сонголтоор) 10-25 минут
4. Төгсгөл – 15 минут

Бэлтгэл

Алхам 1: Аль аль хүйсэд хандах эерэг болон сөрөг хандлагыг илэрхийлсэн жендэртэй холбоотой хэлц үг, зүйр цэцэн үгийн эвлүүлэг бэлдэнэ. Өөрийн соёлын болон бусад соёлын 2-оос доошгүй зүйр цэцэг үг, хэлц үгнээс оруулсан байна (Нэмэлт мэдээлэл: Жендэртэй холбоотой Монгол болон Зүүн Азийн улс оронд дэлгэрсэн хэлц үгс).

- Жендэртэй холбоотой 8 хэлц үг/зүйр цэцэн үг/ сонгож, түүнийг томоор цаасан дээр бичнэ.
- Хэлц үгийг/зүйр цэцэн үг/ үг хэллэгээр нь хайчилж, олон хэсэг болгоод хооронд нь холино. Жишээлбэл:
 - “Хүү өсгөх нь /гахай/бордохтой/ адил.”
 - “Нөхрөө /цадсаны/дараа л/эхнэр/хоолоо/ иддэг.”

(Хайчилсан үгсээ өгүүлбэрээр нь багцална).

- 5-6 багц болгож, баг бүрд нэг багцыг өгнө. Багц тус бүрд эерэг болоод сөрөг утгатай 4-5 хэлц үгийг (Монголын болон өөр улсынх байж болно) хооронд нь сайтар холино. Багуудад хуваарилсан зарим хэлц үг нь давхцах боломжтой.

Алхам 3. (сонголтоор): Монголын соёл дахь эрэгтэй, эмэгтэй хүний үүргийн талаарх мэдээлэл болон нийтийн дуу хөгжим, кино жүжиг, ном зохиол, видео бичлэг, фото зураг, аудио бичлэг урьдчилан бэлдэнэ.

Хамтран сургагчтайгаа нийлж, хэрвээ боломжтой бол 1-2 оролцогч сонгон, дараах үзүүлбэрээс 5-10 минутын дотор жүжигчилсэн тоглолт бэлдэнэ. Тоглолт бүр нийгэм дэх жендэрийн үүргийг тусгаж 5-40 минут үргэлжилнэ. Алхам 3-т үзүүлэх үзүүлбэрийн нийт хугацаа 10 минут:

- Эрэгтэй/эмэгтэй хүний тухай орчин үеийн нэрд гарсан дуу эсвэл ардын дуу дуулах
- Гол дүрийн эрэгтэй/эмэгтэй-г тодотгон харуулсан алдартай эсвэл сонгодог жүжгийн хэсгээс /урлагийн аль ч төрлийх байж болно/ тоглох
- Эрэгтэй, эмэгтэй хүний онцлог шинжийг харуулсан ардын бүжиг бүжиглэх
- Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын харилцааг харуулсан клип, драм эсвэл видео үзүүлэх.

Алхам 1. Хэлц үг эвлүүлэх тоглоом – 15 минут

Баг бүрд 5-6 хүн байхаар оролцогчдыг багуудад хуваана. Баг тус бүрд хэлц үгийн эвлүүлгийг самбарын цаас, самбарын үзгийн хамт тарааж өгнө. Баг бүр:

- Үгсийг эвлүүлж хэлц үг бүтээнэ.
- Нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй хүнд хандах хандлага, тэдний талаарх төсөөлөл, үнэт зүйлийг тусгасан 2-оос цөөнгүй хэлц үг нэмнэ.
- Дараах асуултад хариулаарай:
 1. Хэлц бүр ямар утга санааг агуулсан байна вэ?
 2. Хэлц үг бүр эрэгтэй, эмэгтэй хүн, охид хөвгүүдийн талаар ямар санааг илэрхийлж байна вэ?
 3. Эдгээр хэлц үгийг хэн, яагаад зохиосон гэж бодож байна вэ?
 4. Эдгээр хэлц үгийн утга санаа нь өнгөрсөн үед тохирч байсан уу? Харин өнөөгийн нөхцөлд тохирч байна уу?

Алхам 2. Хэлц үгний утгыг ярилцах – 15-20 минут

Эхний хэлц үгийг оролцогчдын хэн нэгнээр нь чангаар уншуулж, утга санааг нь тайлбарлахыг хүснэ. Энэ мэтээр 6-8 хэлц үгийн утгыг хамтдаа ярилцсаны дараа эвлүүлсэн хэлц үгнүүдээ самбар дээр бүх хүнд харагдахаар бичнэ. Зүйр цэцэн үг, хэлц үгийн хэлэлцүүлгийг хөнгөвчлөх зорилгоор 1-р Алхмын 2-4-р асуултуудыг ашиглаарай.



Сургагч багшид зориулсан зөвлөгөө

Зарим хэлц үгийг өөр орны соёлоос авсан учир оролцогчид тэдгээрийн утгыг сайн мэдэхгүй байж болох юм. Тэдний бодлоор өөр соёлд хамрагдах хэлц үгийг ялгахыг санал болгоорой. Сургагч багш эдгээр хэлц үгийг тайлбарласны дараа тухайн хэлц үгтэй утга санааны хувьд дүйцхүйц хэлц үг манай улс оронд байдаг эсэхийг оролцогчдоос асуугаарай. Магадгүй эвлүүлэн үүсгэсэн гадаад орны хэлц үгийг оролцогчид өөрийн орны хэлц үг гэж андуурч болох юм. Учир нь өөрийн соёлд төстэй хэлц үг байж болно.

Алхам 3. Жендэртэй холбоотой урлагийн тоглолт – (сонголтоор) 10-25 минут

Оролцогчдыг хүсвэл тэд нараар 5 минутаас хэтрэхгүй хугацаанд жүжигчилсэн тоглолт тоглуулж болно. Тухайн жүжигчилсэн тоглолтын талаар ярилцаж, эрэгтэй, эмэгтэй хүний үүрэг болон хандлагад анхаарлаа хандуулаарай. Жүжигчилсэн тоглолтоос өөрийн орны алдартай төгс эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн талаар дүгнэн хэлэлцэнэ.

Алхам 4. Дүгнэлт – 15 минут

Дараах асуултыг ашиглан дасгалын дүгнэлт хийхийг оролцогчдоос хүснэ:

- Эдгээр хэлц үг нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй (хүү, охин) хүний үүргийг хэрхэн тодорхойлж байна вэ? Жишээ нь: Эрэгтэйчүүд/эмэгтэйчүүд юу хийх хэрэгтэй вэ? Тэд юу хийж болох/болохгүй вэ?
- Эдгээр хэлц үгт тусгагдсан жендэрийн үнэт зүйл болон хандлага нь таны, танай гэр бүлийнхний болон бусад хүмүүсийн биеэ авч явах байдал, амьдралдаа хийх сонголтод хэрхэн нөлөөлж байна гэж бодож байна вэ?
- Амьдралдаа ямар нэгэн чухал шийдвэр гаргах үед та эдгээр хэлц үгийн /гол дүрүүд/ талаар заримдаа боддог уу?
- Жендэрийн эдгээр үнэт зүйл, хандлага нь цагийн эрхээр өөрчлөгдсөн үү? Жишээ нь:
 - ✓ Хөвгүүд охидын сурч боловсрох тал дээр
 - ✓ Гэрийн ажил хийх дээр
 - ✓ Гадаа талбай дээр ажиллах тал дээр
 - ✓ Найз нөхдөө сонгох тал дээр
 - ✓ Болзоо болон хуримлах тал дээр
- Та нарын эмээ, өвөөгийн үеийг орчин үетэй харьцуулахад охид, хөвгүүд, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаарх үнэт зүйлийн аль нь хэвээр хадгалагдаж, аль нь өөрчлөгдсөн бэ?
- Ирээдүйд жендэрийн үүрэг өөрчлөгдөх болов уу? Зарим жишээ нэрлэнэ үү?

Насанд хүрэгчид:

- Таны үнэт зүйл, хандлага, хүлээлт хүүхдийн тань амьдралд, тэдний шийдвэр гаргах явцад нөлөөлдөг болов уу?
- Хүүхэд тань заримдаа өөрийн хүслээрээ бус харин таны хүслийн дагуу ямар нэг зүйл хийдэг үү? Хэрвээ тийм бол ямар зүйлийг та нэрлэх вэ?

Дараах санааг нэгтгэж дүгнэлт гаргаарай:

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид хөвгүүд юу хийх хэрэгтэй, ямар зүйлийг хийж болохгүй гэх мэт зүйл дээр нийгэм бүр өөр өөр үнэт зүйл, хандлага, төсөөлөлтэй байдаг. Энэхүү үнэт зүйл, хандлага нь хүмүүсийн бодол, зан үйл ба тэдний амьдралд ихээхэн нөлөөлдөг ажээ.
- Жендэрийн үүргийн талаарх үзэл бодол өөр өөр соёлд төдийгүй нэг соёлын хүрээнд ч ялгаатай байдаг. Энэхүү үзэл бодол, төсөөлөл нь үеэс үед өөрчлөгдөн шинэчлэгддэг билээ.
- Хэн нэгний бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл эсвэл хүйсийн онцлогийг доромжилсон уламжлалт хэллэг, уриа, зүйр цэцэн үг хэрэглэхгүй байх нь зүйтэй. Өнгөрсөн үед охид, эмэгтэйчүүдийг дутуу үнэлж, дорд үзэж байсан нь эрэгтэй хүний давуу талыг хамгаалж, тэдэнд илүү их эрх мэдэл оноосон хэллэг, хэлц үгээр илэрдэг. Харин орчин үед нийгэм, соёл нь цэцэглэн хөгжиж байгаа оронд эмэгтэй хүнийг дорд үзэхээ больж, эрэгтэй хүнтэй адил эрх олгож хэн хэнд нь хариуцлагыг хуваан үүрүүлэх болжээ. Өнгөрсөн үед хэрэглэж байсан хэлц үг, хэллэг нь орчин үеийн бодит байдлыг тусгасан байдлаар өөрчлөгдөх хэрэгтэй.
- Насанд хүрэгчдийн адил хүүхдүүдийн амьдрал ч бас охид хөвгүүдийн талаарх гэр бүл болон нийгмийн хүлээлтээс хамаардаг.
- Энэхүү хүлээлт нь нь хүүхдэд шууд болон шууд бус замаар нөлөөлж, тэднийг өөр байхыг шаардан сонголтоо өөрийн хүслийн дагуу хийж чадахгүйд хүргэдэг. Өөрөөр хэлбэл тэд өөрсдийн хүслээрээ бус олон нийтийн жишгийн дагуу хүсээгүй сонголтоо хийх нь олонтоо.



Нэмэлт мэдээлэл: Жендэртэй холбоотой Монгол болон Зүүн Азийн улс оронд дэлгэрсэн хэлц үгс

Хэлц үгс	Тайлбар
Монгол: “Эр хүн зоригтой бол чоно чацга алдана” “Эм хүний үс урт, ухаан богино” “Эхнэрийн сайныг гэрт нь орж мэдэх Нөхрийн сайныг гадаа нь гарч мэдэх”	Монгол: - Эрэгтэйчүүд идэвхтэй, зоригтой, ноёрхуу шинжтэй учраас амьтан хүртэл айдаг хэмээн үзсэн байна. - Эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс дорд үзэх, хүч чадлыг нь дутуу үнэлэх, ухаанаараа дутуу гэж үзжээ. - Эмэгтэйчүүдийг сайн эзэгтэй, сайн ээж, хоолоо хийж, гэрээ цэвэрлэдэг, хүүхдээ төрүүлж өсгөдөг, хүүхдийн хүмүүжлийг түлхүү анхаардаг, харин эрэгтэйчүүдийг гэр бүлээ авч явдаг, мөнгө олдог, адуу малаа хариулдаг, олон нийтийн ажилд оролцдог, мэргэжлийн хувьд амжилт гаргадаг, улс төрийн идэвхтэй гэж тодорхойлдог байна.
Хятад: “Эмэгтэйчүүд тэнгэрийн талтай тэнцэнэ” “Анхны хүүхэд охин байх нь одос үхэртэй байснаас дээр” “Хүүгээ хүмүүжүүлээгүй эцгийн буруу”	Хятад: 1960-1970-аад оны үед Хятадууд энэ хэлцийг өргөн хэрэглэдэг байсан. Уг хэлц үг нь эрэгтэйчүүдийн хийж чаддаг зүйлийг эмэгтэйчүүд ч хийж чаддаг бөгөөд эрэгтэйчүүдтэй мөр зэрэгцэн ажиллаж хөдөлмөрлөх чадвартай хэмээн эмэгтэйчүүдийн хувь нэмрийг үнэлсэн байна. - Гэрийн ажилд тустай учраас анхны хүүхэд охин байсан нь дээр гэж үздэг. - Эцэг эх нь хүүхдийнхээ боловсролд анхаарах үүрэгтэй.
Лаос: “Хүү өсгөх нь гахай бордохтой адил.” “Нөхрөө цадсаны дараа л эхнэр хоолоо иддэг.” “Эмэгтэй хүн төрийн хэргээс хол, лам хүн гэрийн ажлаас хол”	Лаос: - Хүү бол насанд хүрснийхээ дараа өөр нэгэн айлын гэрийн эзэн болоод явна гэсэн утгатай. - Нөхөр нь эхлээд хоолоо идэх эрхтэй. - Эмэгтэй, эрэгтэй хүмүүс өөртөө хамаагүй асуудалд санаа зовж, оролцох хэрэггүй.
Кхмер: “Эрчүүд зөгий бол бүсгүйчүүд цэцэг юм.” “Эрчүүд алт/алмаз бол эмэгтэйчүүд цагаан даавуу юм.” “Эмэгтэй хүн бол бүх дэлхийн эх юм.” “Ээж нь үхсэнээс аав нь үх.”	Кхмер: - Эрэгтэйчүүд эмэгтэй хүний гоо сайханд татагддаг. - Эрэгтэй хүн эмэгтэй хүнээс илүү үнэтэй. Гэрлэхээс нь өмнө эмэгтэйчүүдийн цэвэр ариун байдлыг хамгаалах хэрэгтэй. Гэрлэхээсээ өмнө бэлгийн харилцаанд орох нь эмэгтэй хүний нэр төрд сэвтэй. - Эмэгтэй хүн бүр ээж болж, бусдыг өсгөж хүмүүжүүлдэг. - Гэр бүлийн оршин тогтнох нь ээжээс илүү хамааралтай.

Тайланд: 1. Эрэгтэй хүн бол зааны урд хөл, эмэгтэй хүн хойд хөл нь юм 2. Охинтой болно гэдэг байшингийнхаа урд жорлонтой болсонтой адил	Тайланд: 1. Эрэгтэйчүүд удирдагч, харин эмэгтэйчүүд бол дагалдагч юм. 2. Охин хүүхэд ааш муутай бол гэр бүлийнхээ нэр төрийг маш амархан сэвтүүлдэг.
Вьетнам: 1. “Эрчүүд гэртээ ойрхон, эхнэрүүд галдаа ойрхон.” 2. “Арван охинтой байх нь хүүхэдгүйтэй адил, нэг хүүтэй байх нь хүүхэдтэй гэсэн үг.”	Вьетнам: 1. Эрэгтэй хүн ихэвчлэн гадуур ажлаа зохицуулж, эмэгтэй хүн гэр доторх ажлаа хийдэг гэсэн утгатай. 2. Хүүтэй байна гэдэг охинтой байхаас илүү чухал.
Зүүн өмнөд азийн уугуулууд: 1. “Төрсөн гэртээ эцгээ сонс, өөрийн гэртээ нөхрөө сонс” (Mien) 2. “Тэнэг хүн л эхнэрээсээ айдаг.” (Mien) 3. “Сайн эхнэр шөнөөр гардаггүй.” (Pagayerñor or Karen) 4. “Есөн хүү байгаад нөхрийг орлохгүй.” (Hmong) 5. “Охинтой байх нь шилэн хоргонд үймэх загастай байх мэт, хүүтэй байх нь догширсон бухтай байх адил.” (Tai Lue and Shan)	Зүүн өмнөд Азийн уугуулууд: 1. Эмэгтэйчүүд амьдралынхаа турш эрэгтэй хүнийг дагаж амьдардаг. 2. Эхнэрийнхээ хүслээр асуудлыг шийддэг байх нь тэнэг эрийн шинж. 3. Эмэгтэйчүүд гэртээ байж, ямар нэгэн зүй бус зүйл хийх ёсгүй. 4. Хүү бол нөхөр шиг чухал биш юм гэсэн утгатай. 5. Ааш муутай охин гэр бүлийнхээ нэр төрийг гутаадаг бол хөвгүүдийг жолоодон удирдахад бэрх гэсэн санааг агуулж байна

Сэдэв 3.3 Гэр бүлээ аз жаргалтай байлгах нь



Агуулга

Энэ сэдвийн хүрээнд гэр бүлийн харилцааны тухай оролцогчдын ойлголтыг хэлэлцэнэ. Оролцогчид гэр бүлээ аз жаргалтай байлгахад юу чухал болохыг хэлэлцэж, гэр бүлийн гишүүдийн зан үйл бусдадаа хэрхэн нөлөөлж, тухайн гэр бүлийн ерөнхий тэнцвэрийг хадгалах, аз жаргалтай байхад ямар үүрэгтэй болох талаар ярилцана. Мөн гэр бүлийн зөрчлийг хэрхэн шийдэж болох тухай суралцах болно.



Үндсэн мэдээлэл

- Гэр бүл аз жаргалтай байхад юу хэрэгтэй вэ гэвэл эрүүл мэнд, аюулгүй байдал, сэтгэл зүйн тэнцвэртэй байдал, тэгш эрх, ажлын үүрэг хариуцлагаа хуваалцах, шийдвэр гаргахад оролцох, орлогоо хуваалцах, өөрийн мөн чанараа нээн илрүүлж, өөрийгөө бүрэн дүүрэн хөгжүүлэх боломж, гишүүн бүрд, ялангуяа хүүхдүүдэд нээлттэй байх байдаг.
- Гэр бүлийн амьдрал дахь аз жаргалгүй байдлыг өөрчлөх боломж хэзээд байдаг. Зарим нөхцөл байдлыг өөрчлөх арай хялбар байдаг ч гэр бүлийн гишүүд бүгд эрүүл чийрэг, хариуцлагатай, бие биеэ хайрладаг, хүндэлдэг бол гэр бүл аз жаргалтай байх боломжтой.



Дасгалууд

3.3.1 Гэр бүлийн аз жаргалыг сонгох нь

3.3.2 Гэр бүлийн зөрчлийг шийдвэрлэх нь



Холбогдох сэдвүүд

1.2 Миний гэр бүл ба миний орон нутаг

3.1 Хүү, охин байхын ялгаа нь юу вэ?

3.2 Жендэрийн үүргийн талаарх үнэт зүйл ба хандлага

4.1 Гэрт хэн нь юу хийдэг вэ, хэн нь үгээ хэлдэг вэ?

6.2 Хайр сэтгэл ба гэрлэлт

8.1 Хүчирхийлэлд хэрхэн “Үгүй” гэж хэлэх вэ

11.1 Үүрэг хариуцлага

Дасгал 3.3.1 Гэр бүлийн аз жаргалыг сонгох нь



Зорилго

- Гэр бүлийн харилцааны талаарх өөрийн хандлагаа таних
- Гэр бүл аз жаргалтай байхад юу чухал болохыг ойлгох
- Хүүхдийнхээ өмнө хүлээх эцэг эхийн үүрэг хариуцлагыг ухамсарлах
- Гэр бүлийн хүрээнд хүүхэд, өсвөр насныхны эдлэх эрхийн талаарх өөрийн ойлголтоо үнэлэх



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид



Хугацаа

45-60 минут



Суудал зохион байгуулалт

Хагас тойрог байдлаар сууж ярилцах ба зураг өлгөх, зургуудыг очиж харах хангалттай зайтай байхаар тооцно



Ашиглах материал

- Гэр бүлийн нөхцөл байдлыг харуулсан 10 зурагт хуудасны 1-2 багц (Сургалтын хэрэглэгдэхүүн 3.3.1 А)
- 2,5 см х 7,5 см хэмжээтэй улаан болон хар хуудас (оролцогч бүрд өнгө бүрээс 10 ш.)
- 10 ш. саналын хайрцаг (саналын хуудас хураах зориулалттай хайрцаг)
- Цаасан скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

3.3.1 А: Гэр бүлийн нөхцөл байдлын зурагт карт

Нэмэлт мэдээлэл: Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал болон тодорхойлолтууд (Дасгал 3.1.1)

Нэмэлт мэдээлэл: Гэр бүлийн нөөц болон давуу тал (Дасгал 4.2.1)



Сургалт зохион байгуулах алхмууд⁶

1. Гэр бүлийн нөхцөл байдлын зурагт хуудсыг танилцуулах – 15 минут
2. Гэр бүлийн нөхцөл байдалд хэрхэн саналаа өгөхийг тайлбарлах – 5 минут
3. Гэр бүлийн нөхцөл байдалд саналаа өгөх – 5-10 минут
4. Саналын хуудас тоолох – 5-10 минут
5. Хэлэлцүүлэг – 10-15 минут
6. Дүгнэлт – 5 минут

Бэлтгэл

Алхам 1. Гэр бүлийн нөхцөл байдлын 10 ш. зурагт хуудсыг хүн бүрд харагдахаар хананд байрлуулна. Зураг бүрийн урд санал хураах хайрцаг байрлуулна. Хайрцгууд болон зургуудыг харгалзуулан дугаарлана.

Алхам 1. Гэр бүлийн нөхцөл байдлын зурагт хуудсыг танилцуулах – 15 минут

Гэр бүлийн нөхцөл байдлын зурагт хуудсыг үзүүлж, гэр бүлийн гишүүдийг танилцуулна (илүү сонирхолтой болгохын тулд гэр бүлийн гишүүн бүрд танил нэр онооно).

Зурагт хуудас бүрийг оролцогчид нэг нэгээр тайлбарлан ярьж, тухайн нөхцөлийн талаар бүгд адилхан ойлголт авсан байхад анхаарна. Гэхдээ үүнд хэт их цаг зарцуулах шаардлагагүй.

Алхам 2. Гэр бүлийн нөхцөл байдалд хэрхэн саналаа өгөхийг тайлбарлах – 5 минут

Оролцогчдоос зурагт хуудас бүр дээрх нөхцөл тухайн гэр бүлийг аз жаргалтай болгож чадах эсэх талаар асууна. Өөрийн саналаа хоёр өнгийн хуудасны нэгийг ашиглан илэрхийлэхдээ зураг тус бүрийн доод талын хайрцагт зөвхөн нэг хуудас хийнэ.

- Хэрэв тухайн нөхцөл гэр бүлийг аз жаргалтай болгож чадаж байвал улаан хуудас,
- Хэрэв тухайн нөхцөл гэр бүлийг аз жаргалтай болгож чадахгүй бол хар хуудсыг сонгоно.

Эдгээр нөхцөлүүд гэр бүлийн амьдралд түгээмэл тохиолддог. Оролцогчид шийдвэр гаргахад хүндрэл учирвал ийм нөхцөл байдал өөрийнх нь гэр бүлд үүсэхийг хүсэж байгаа эсэхийг асуугаарай.

Оролцогчдыг саналаа хэрхэн өгөхийг ойлгосон эсэхийг тодруулаарай. Хүүхдүүдийн тухайд саналаа хэрхэн өгөхийг биечлэн үзүүлж болно. Бүгд ойлгосон үед 10 улаан, 10 хар хуудас тарааж өгнө.



Санал хураалт явуулахад хэрэглэх материалыг хэрхэн сонгох зөвлөмж

Хэрэв хар, улаан хуудас болон саналын хайрцаг бэлтгэхэд хүндрэлтэй бол сургагч нар хоёр өөр өнгийн самбарын үзэг, хуудас цаас ашиглан санал авч болно.

⁶ WWRGE Manual-Cambodia by Rosalinda Terhorst et al. (ILO: Bangkok, 2004), Module 3.1 Self Awareness – Vote for Change.


Алхам 3. Гэр бүлийн нөхцөл байдалд саналаа өгөх – 5-10 минут

Санал өгч эхэлнэ. Санал хураалтыг богино хугацаанд цэгцтэй явуулахын тулд:

- Оролцогчдыг хоёр эгнээ болгож, хамгийн эхний болон сүүлийн зургийн захад жагсаан зогсооно.
- Хамгийн урд зогсож байгаа хүн эхний зургийн доорх хайрцагт саналаа хийгээд, дараагийн зураг руу явсны дараа хоёр дахь хүн саналаа хийх зэргээр бүх хүн 10 зурагт саналаа өгч, 10 хуудастай үлдсэнээр санал хураалт дуусах болно.

Алхам 4. Саналын хуудас тоолох – 5-10 минут

Оролцогчдоос хоёр хүнийг сайн дураараа санал тоолж, үр дүнг танилцуулахыг хүсэх ба явцыг бүгдэд ил харагдахаар зохицуулах хэрэгтэй.



Саналын хуудас тоолоход анхаарах зүйлс

Хагас метр орчим урттай хоёр туузыг зураг тус бүрийн дор уртааш нь байрлуулж, дээр нь 5-6 см-ийн зайтай цаасан скоч хайчлан байрлуулж, улаан хуудсаа нэг талд, хар хуудсаа нөгөө талд наалдахаар тогтоож бэлдээрэй.

Алхам 5. Хэлэлцүүлэг – 10-15 минут

Зураг бүрийн дор бүх оролцогч саналаа өгч дууссаны дараа үр дүнг хэлэлцээрэй. Дараах асуултаар хэлэлцүүлгийг чиглүүлж болно:

- Оролцогчид зураг бүрд ижил санал өгсөн үү? (зарим зургийн хувьд өөр өөр байж болно).
- Аль зураг дээр олонхын санал нийлсэн байна вэ? (гэр бүлд аз жаргал авчрах, эсвэл эсрэгээрээ байх тал дээр бараг л бүгд адил санал өгсөн).
- Ямар зургууд холимог санал авсан байна? Яагаад энэ нөхцөл гэр бүлийг аз жаргалтай эсвэл аз жаргалгүй болгоно гэж бодож байна вэ?
- Аз жаргалгүй гэсэн хамгийн олон санал авсан зурагтай холбогдуулан, “Чиний бодлоор юуг, яаж өөрчилбөл энэ гэр бүл аз жаргалтай байх боломжтой вэ?” хэмээн асууна.

Аз жаргалтай гэр бүлийн онцлогийг тоочин багцалбал:

- **Эрүүл, аюулгүй амьдрал:** эрүүл энх, аюулгүй амьдрахад шаардлагатай гол зүйл бол орох орон гэр, хоол унд, хувцас, ажил байдаг.
- **Аз жаргал, сэтгэл зүйн хувьд тэнцвэртэй байдал:** гэр бүлээрээ хамтдаа цагаа өнгөрөөж, бие биеэ халамжлан хайрлаж, хүндэлж, хүлээцтэй хандаж, уучлан өршөөх
- **Тэгш байж, хуваалцах:** үүрэг хариуцлага, боломж, ажлын ачаалал, шийдвэр гаргалт, орлогоо хуваалцах замаар бие биедээ туслах
- **Өсөн дэвжих боломж:** гэр бүлийн гишүүн бүрд, ялангуяа хүүхдүүдэд хөгжин дэвжих орон зай, боломж бололцоог олгох

Алхам 6. Дүгнэлт – 5 минут


Дасгал ажлыг дараах байдлаар багцлан дүгнэнэ:

- Гэр бүлийн гишүүн бүр нас, хүйс, эрүүл мэндийн байдлаасаа үл хамааран хүндлүүлж харьцах, өөрийн мөн чанараа нээн илрүүлж, өөрийгөө бүрэн дүүрэн хөгжүүлэх эрхтэй
- Хүү ч бай, охин ч бай сурч боловсрох эрхээ эдлэх ёстой бөгөөд амьдралын асуудлаа өөрөө шийдэх, тэр дундаа хэзээ хэнтэй гэрлэхээ шийдэх эрх чөлөөтэй байх ёстой
- Эхнэр нөхөр хоёул хэзээ хэдэн хүүхэдтэй болохоо шийдэх эрхтэй.
- Гэр бүлийн хүчирхийлэл бол хууль зөрчиж байгаа хэрэг юм
- Гэр бүлийн амьдралын таагүй нөхцөлийг өөрчлөх боломжтой. Зарим нөхцөл байдлыг өөрчлөх арай хялбар байдаг ч гэр бүлийн гишүүд бүгд эрүүл саруул, хариуцлагатай байж, бие биеэ халамжилж, хайрлаж, хүндэлж; боломж, үүрэг хариуцлага, ажлын ачаалал, шийдвэр гаргалт, орлогоо шударга хуваалцахад бэлэн байвал гэр бүл аз жаргалтай байж чадна.




Сургалтын хэрэглэгдэхүүн 3.3.1 А: Гэр бүлийн нөхцөл байдлын зурагт карт


Зааварчилгаа: 1-р алхамд хэрэглэхээр дараах 10 зурагт хуудсыг урьдчилан бэлдэн дасгал ажилдаа хэрэглэнэ.



1. Гэр бүлийн оройн хоол



2. Эгч дүүс хамтдаа сургуульдаа явж байна.



3. Хүүхэд гэр бүлтэйгээ салах ёс хийж байна.



4. Том эгч нь өвчтэй дүүгээ гэртээ асарч байна.




5. Гэр бүлийн маргаан



6. Аав ээж нь өрхийн санхүүг хэлэлцэж байна



7. Нэг гэрт олон хүн амьдарч байна.



8. Гэр бүлээрээ баяр тэмдэглэж байна.



9. Эцэг, эх нь архи ууж, мөрийтэй тоглож, хүүхдүүд нь гэрийн ажлаа хийж байна.



10. Аав ээжүүд нь сургууль дээр багштай уулзаж байна.

Дасгал 3.3.2 Гэр бүлийн зөрчлийг шийдвэрлэх нь



Зорилго

- Гэр бүлийн зөрчил нь заримдаа гишүүдийн үнэт зүйлсийн зөрүүтэй байдлаас үүсдэгийг ойлгох
- Гэр бүл үүрэг хариуцлагыг эерэг талаас нь харж сурах
- Гэр бүлийн гишүүдийн хоорондын зөрчлийг шийдэх аргуудыг хэрэглэж турших



Зорилтот бүлэг

Хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид (хүүхдийг залуучууд, насанд хүрэгчдээс тусад нь оролцуулна)



Хугацаа

45-60 минут



Суудал зохион байгуулалт

Ширээ тойрч, баг болон сууна.



Ашиглах материал

- Сургалтын хэрэглэгдэхүүн 3.3.2.А-с баг бүрд нэг зургийг хувиалан тараана
- Өнгийн харандаа, үзэг
- Цаасан скоч



Сургалтын хэрэглэгдэхүүн

3.3.2 А: Асуудлыг шийдье



Сургалт зохион байгуулах алхмууд

1. Эрхээ эдлэхтэй холбогдон үүсэж болох зөрчлүүд – 5 минут
2. Багийн ажил – 15-20 минут
3. Багийн ажлаа танилцуулж, хэлэлцэх – 20-25 минут
4. Сурсан гол зүйлс – 5-10 минут

Алхам 1. Эрхээ эдлэхтэй холбогдон үүсэж болох зөрчлүүд – 5 минут

Ямар ч гэр бүл заримдаа дотроо зөрчилдөж, гишүүд нь нэг нэгэндээ сэтгэл дундуур байх нөхцөл үүсэж болохыг тайлбарлана. Оролцогчдоос ийм жишээ татахыг хүснэ.

Гэр бүлийн хэн нэгэн гишүүн өөрийн эрхээ эдлэх үед өөр хэн нэгний үнэт зүйл эсвэл эрхтэй зөрчилдөж болохыг нэмж тайлбарлана. Жишээлбэл, хүү эсвэл охин нь сургуульд явахыг хүсэвч аав ээж нь сургуулиасаа гарч, дүүгээ харах эсвэл ажиллаж мөнгө олох нь дээр хэмээн үзэх.

Заримдаа хүмүүс өөрөөр сэтгэдэг. Жишээ нь, хүүхэд аливаа хүчирхийллээс хамгаалагдах эрхтэй гэж үздэг эцэг эх хааяа өөрсдөө хүүхдээ буруу зүйл хийснийх нь төлөө гар хүрэх нь бий. Харин хүүхдийн тухайд биед нь гар хүрсэн л бол хүчирхийлэл мэт санагддаг. Гэхдээ зарим тохиолдолд өөрийнх нь эрх зөрчигдөж байгааг хүүхэд мэдэхгүй байж болно. Энэ дасгалыг гүйцэтгэснээр оролцогчид дээрх зөрчлийг хэрхэн шийдэж болох талаар санаа авах болно.

Алхам 2. Багийн ажил – 15-20 минут

Оролцогчдыг 4-5 хүнтэй багуудад хувааж, баг бүрд Сургалтын хэрэглэгдэхүүн 3.3.2 А: Асуудлыг шийдье хэсгээс нэг нэг хуудас хувилж өгнө. Бүх зургийг эсвэл хамгийн тохиромжтой гэсэн зургуудыг хэрэглэж болно. Зарим багт хуваарилсан зураг давхардаж болно.

- Багуудыг эхний хоёр цонхон дахь зургийг ажиглан, ямар аргаар тухайн зөрчлийг шийдэж болох тухай эргэцүүлэхийг хүснэ. Дараагийн 4 цонхонд үйл явдлын өрнөл, төгсгөлийг буюу өөрсдийн шийдлээ зургаар эсвэл бичгээр илэрхийлэхийг хүснэ. Хамгийн гол нь тухайн зөрчлийг шийдвэрлэсэн байх ёстой.
- Тухайн зөрчлийг хэрхэн шийдсэнээ бусад багууддаа жүжигчилсэн хэлбэрээр эсвэл багаараа үзүүлэн дээр танилцуулахад бэлтгэнэ.

Алхам 3. Багийн ажлаа танилцуулж, хэлэлцэх – 20-25 минут

Багуудыг өөрсдийн даалгаврыг 2-3 минутад багтаан танилцуулахыг хүсээд, даалгавар бүр дээр дараах асуултаар богинохон хэлэлцүүлэг өрнүүлнэ:

- Даалгаварт үзүүлсэн зөрчил нь юу байсан бэ?
- Энэ зөрчлийн явцад ямар эрх/эрхүүд зөрчигдсөн бэ? (даалгаврын товчийг доорх жагсаалтаас харна уу)
- Зөрчлийг шийдэх гарцуудыг олоход хялбар байв уу? Яагаад?
- Хамгийн боломжит хувилбар нь юу гэж бодож байна? Яагаад?
- Яаж хүн бүрийн санаанд нийцсэн шийдэлд хүрэх вэ?
- Та нар бас заримдаа иймэрхүү нөхцөлтэй тулгардаг уу? Тийм бол та яг юу хийдэг вэ?

Хэлэлцүүлгийг гэр бүлийн харилцааны асуудалд чиглүүлж, зарим зөрчил яагаад үүсдэгийг шинжиж, тийм тохиолдолд хэрхэн шийдвэрлэвэл зохих тухай хэлэлцэнэ.

- Заримдаа эцэг эхийн хүсэж байгаа зүйл хүүхдийн хүслээс зөрдөг. Ийм тохиолдолд яах ёстой вэ?
- Зөрчил илүү гүнзгийрч, хүч хэрэглэх нөхцөл бүрдэхэд та юу хийх вэ?

Зураг 1: Гэрлээ – сурч боловсрох эрх, эрүүл амьдрах эрх

Боломжит гарцууд:

Гэр бүлийн гишүүд өвчтэй хүүхдийг халамжлах үүргээ хуваалцаж, охиныг ямар нэгэн байдлаар үргэлжлэн суралцах нөхцөлөөр хангах

Зураг 2: Нандин, Эрдэнэ хоёр – хэзээ гэрлэхээ шийдэх эрх, сурч боловсрох эрх, аюулгүй үр хөндүүлэх эрх

Боломжит гарцууд:

- Нандин, Эрдэнэ хоёр гэрлэх эсэхээ өөрсдөө шийдэх ба Нандин хүүхдээ төрүүлж, хамтдаа (эцэг эхийнхээ тусламжтайгаар) хүүхдээ өсгөж, сургуульдаа үргэлжлэн суралцах
- Нандин (хуулиар зөвшөөрсөн бол) жирэмсний 12 долоо хоног хүрэхээс нь өмнө аюулгүй үр хөндөлт хийлгэж, Нандин, Эрдэнэ хоёр үргэлжлүүлэн суралцах.

Зураг 3: Марал – өөрийгөө илэрхийлэх эрх, хайрлуулж халамжлуулах эрх, аюул ослоос хамгаалуулах эрх

Боломжит гарцууд:

- Марал малчин айл түүнийг сайн халамжлахгүй, зодсон талаар эцэг эхдээ хэлэх. Марал болон түүний эцэг, эх хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн талаар холбогдох газар мэдээлэх. Маралыг малчин айлаас буцааж авах.
- Маралын эцэг, эх гэр бүлийнхээ ахуй амьдралыг дээшлүүлэх өөр арга зам хайж, Маралыг малчин айлаас буцааж сургуульд нь оруулна.

Зураг 4: Мөнхөө - Найз нөхдөө сонгох, өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх эрх

Боломжит гарцууд:

Мөнхөө панк, рок хөгжим сонирхдог найз нөхдийнхөө талаар аав, ээждээ дахин тайлбарлахыг оролдоно. Тэвчээртэй байж, уурлахгүй байхыг хичээх хэрэгтэй. Мөнхөө нэг, хоёр найзыгаа эцэг эхтэйгээ танилцуулж болно. Эцэг эх нь түүний найзуудыг таньдаг болсноор өсвөр насны хүүхдүүд янз бүрийн хөгжим, хувцасны загвар сонирхдог жирийн л хүүхдүүд болохыг ойлгож магадгүй юм. Зарим өсвөр насныхан бусдаас ялгарах дуртай байдаг бөгөөд эцэг эх нь хүүхдийнхээ төлөө үүрэг хариуцлага хүлээсэн л бол өөрийгөө илэрхийлэх боломжийг тэдэнд олгох хэрэгтэй.

Зураг 5: Согтуу аав ууртай байна – хайрлуулж халамжлуулах эрх, хамгаалуулах эрх

Боломжит гарцууд:

Хүүхдүүд хөршүүд эсвэл хамаатан садан, нийгмийн ажилтан зэрэг итгэж болох хүмүүст хандан тусламж хүсэх хэрэгтэй. Нөхцөл байдал сайжрахгүй бол ээж нь хүүхдүүдээ аваад хамаатныдаа амьдрах, эсвэл хүчирхийллээс хамгаалах байр зэрэг аюулгүй газар очих хэрэгтэй. Аав нь харин архидалтын асуудлаа шийдэж, эхнэр хүүхдээ зовоохоо болих хэрэгтэй.

Алхам 4. Сурч авсан гол зүйл – 5-10 минут

Дасгал ажлаас юу мэдэж авснаа бусадтайгаа хуваалцахыг хүснэ. Санаа бодлоо чөлөөтэй хуваалцахыг дэмжинэ.

Хэлэлцүүлгийн гол санааг багцлан танилцуулсны дараа доорх зүйлсийг онцлон дурдана:

- Гэр бүлийн гишүүдийн ялгаатай үнэт зүйл нь гэр бүлийн харилцаанд нөлөөлж болно.
- Гэр бүлийн хэн нэгэн гишүүний эрхийг хангахын тулд бусад гишүүний эрхийг зөрчиж болохгүй.
- Бусдын үнэт зүйл, эрх чөлөө, нэр хүндийг хүндэлж харилцсанаар зөрчлөөс сэргийлж болно.
- Зөрчлийн үед ч эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ үндсэн хэрэгцээ болон аюулгүй байдал, хамгааллыг хангах үүрэгтэй.
- Гэр бүл дэх хүчирхийллийг хэзээ ч хүлээн зөвшөөрч болохгүй. Энэ нь Монгол улсын хуулиар хориотой.
- Гэр бүлд нь хүндрэлтэй нөхцөл байдал тулгарсан бол зохих тусламж дэмжлэгийг хүсэх хэрэгтэй.
- Заримдаа хэн нэгэнд золгүй зүйл тохиолдож болох ба ийм үед гэр бүлийнхэн нь шүүн хэлэлцэхээс илүүтэй хайр халамжаа харамгүй зориулах нь чухал байдаг.



Сургалтын хэрэглэгдэхүүн 3.3.2 А: Асуудлыг шийдье

Зааварчилгаа: Зургуудыг хувиан олшруулж, дасгалын үеэр баг тус бүрд нэг нэгийг өгнө. Зарим багуудад зургууд давхардаж болно (Оролцогчдын түвшин, насны ангиллаас шалтгаалж тэдэнд хамгийн тохиромжтой 3-4 зургийг сонгон ажиллуулж болно).

Зураг 1: Гэрлээ

15 настай Гэрлээ 3 дүүгийн хамтаар аз жаргалтай амьдардаг байв. Гэрлээ хичээл номдоо сайн, сургуульдаа явах дуртай бөгөөд том болоод эмч эсвэл сувилагч болохыг мөрөөддөг.



Гэтэл Гэрлээ мөрөөдлөө биелүүлэх боломжгүй болов. Нэг дүү нь осолд орж, ноцтой гэмтэл авсан тул аав ээж нь Гэрлээг сургуулиасаа гарч, дүүгээ харах хэрэгтэй хэмээн шийджээ.



Зураг 2: Нандин, Эрдэнэ хоёр

16 настай Эрдэнэ Нандин гэдэг найз охинтой. Найз охин нь мөн 16 настай бөгөөд нэг сургуульд сурдаг аж. Бие биедээ маш их хайртай учир хааяа бэлгэвчтэй, хааяа бэлгэвчгүйгээр дотно харилцаанд ордог болсноор хэдэн сар болов. Нэг л өдөр охин жирэмсэн болсноо мэдэв.



Охины эцэг, эх энэ тухай мэдсэн даруйдаа тэднийг гэрлэх хэрэгтэй гэв. Харин хүү охин хоёр хоёул айж байлаа. Хэдийгээр бие биедээ хайртай ч хүүхэдтэй болох цаг болоогүй мэт санагдана. Тэд уг нь үргэлжлүүлэн суралцаж, ирээдүйгээ өөрөөр төсөөлж байсан аж. Охин найдвартай үр хөндөлтийг хүсэж байсан ч эцэг эх нь тэднийг гэрлэхгүй бол гэрээсээ хөөнө гэжээ.



Зураг 3: Марал

Марал 12 настай хүү, айлд мал малладаг. Марал сургуульдаа сурах дуртай боловч аав ээж нь түүнийг сургуулиас гаргаж, малчин айлд ажил хийлгэхээр явуулсан. Тэр айл тийм ч сайн байдаггүй, Маралыг олон цагаар ажиллуулдаг.



Марал өглөөнөөс орой болтол мал маллаж, бас дээр нь гэрийн ажил хийдэг. Марал ядарч байгаагаа, мөн бага зэрэг амралт хэрэгтэй байгаагаа малчны гэр бүлийнхэнд хэлсэн боловч, тэд битгий залхуураад бай, улам сайн ажиллах хэрэгтэй гэж хэлжээ. Нэг өдөр Марал маш их ядарч, санамсаргүй 2 аяга унагаж хагалсан. Гэрийн эзэн Маралыг маш хүчтэй зоджээ.




Зураг 4: Мөнхөө

Мөнхөө өсвөр насны хүү. Тэр панк рок хөгжим сонирхдог найзуудтай. Түүний найзууд ихэвчлэн панк-рок загвараар хувцасладаг. Хүмүүс Мөнхөөгийн найзуудыг сонин, муу хүүхдүүд гэлцдэг.



Мөнхөөгийн эцэг эх хүүг нь уруу татаж байна хэмээн найз нартайгаа уулзахад нь сэтгэлээр маш их унадаг. Мөнхөө найз нарыгаа сайн хүүхдүүд, мансууруулах бодис хэрэглэж асуудалд орох хүүхдүүд биш гэж эцэг эхдээ тайлбарлахыг хичээсэн. Гэвч эцэг эх нь түүнд итгэлгүй найз нартайгаа уулзахыг хориглосон. Одоо Мөнхөө эцэг эхтэйгээ ярилцахыг хүсэхгүй байгаа.



Зураг 5: Согтуу аав ууртай байна

Аав нь ахиад л согтуу ирээд ээжтэй нь хэрүүл хийж эхлэв. Энэ байдал ойр ойрхон давтагдах болсоор удаж байна. Их согтсон үедээ аав нь огт өөр хүн шиг болж, хүн бүрд уураа гаргаж эхэлдэг.



Энэ удаа аавд нь зодуулсан ээжийн нүүр цусаар будагдаж, нүд нь хавджээ. Үүнээс болж хүүхдүүд маш их айж, уурлаж, гомдож байлаа. Ээжийгээ хамгаалах гэж оролдоод өөрсдөө зодуулсан учир тэд яахаа ч мэдэхгүй байв.



УНШИХ МАТЕРИАЛ

Ainsworth, Claire, "Sex redefined," *Nature*, 18 February 2015, <https://www.nature.com/news/sex-redefined-1.16943>

Department for International Development (DFID), *Gender Manual: A Practical Guide for Development Policy Makers and Practitioners*, DFID: UK, 1992.

Gender Equality Network (GEN), *Raising the Curtain, Cultural Norms, Social Practices and Gender Equality in Myanmar*, Yangon, 2015.

Haspels, Nelien & Suriyasarn, Busakorn, *Promotion of Gender Equality in Action against Child Labour and Trafficking*, ILO: Bangkok, 2003.

ILO, *ABC of Women Workers' Rights and Gender Equality*, ILO: Geneva, 2000.

ILO, *Gender Mainstreaming Strategies in Decent Work Promotion: Programming Tools – GEMS Toolkit*, Bangkok, 2010.

Terhorst, Rosalinda, Haspels, Nelien, Gender and Development for Cambodia (GAD/C) & Expansion of Employment Opportunities for Women (EEOW), *Women Workers' Rights and Gender Equality: Easy Access for Workers in Cambodia (WWRGE Manual-Cambodia)*, ILO: Bangkok, 2004.

UNFPA, *Trainers' Guide for CSE for TVET*, UNFPA-Lao PDR, 2019

Peace Corps: *World Wise Schools, Educators Resources*, <https://www.peacecorps.gov/educators/>.

Амьдрах ухааны сургалт

Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо

Модуль 3. Гэр бүл, нийгэм дэх тэгш байдал

Энэхүү сургалтын багцыг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж буй "Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем(GSP+)-д Монгол Улсын статусыг тогтвортой хадгалах нь төслийн II үе шат"-ны хүрээнд гаргав. Сургалтын багцад тусгагдсан үзэл бодол нь Европын Холбооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ilo.org/mongolia хаягаар авах боломжтой.